Монгол Улсын Үндэсний статистикийн газар




# Монгол Улсын хүн ам, орон сууцны 2000 оны тооллого явуулах журам, тооллогын хуудас нөхөх журам

## ЗААВАР

Улаанбаатар хот, 1999 он

**Монгол Улсын Үндэсний
Статистикийн газрын даргын
1999 оны 10-р сарын 28-ны
өдрийн 171 тоот тушаалаар
батлав.**

# Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого явуулах журам, тооллогын хуудас нөхөх заавар

*Хүн ам, орон сууцны тооллогын комисс, түр товчооны ажилтан, тоологч, шалгагч нарт зориулав.*

Үндэсний статистикийн газрын
Хүн амын тооллого, судалгааны товчоо
1999 он

## Гарчиг

**Бүлэг-I.** 1

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогыг явуулах эрх зүйн үндэс, шаардлага, зорилго, ач холбогдол

**Бүлэг-II.** 4

Хүн ам, орон сууцны тооллогын тодорхойлолт, хугацааны тов, хамрах хүрээ

**Бүлэг-III.** 7

Хүн ам, орон сууцны тооллого явуулах үндсэн зарчим, журам

**Бүлэг-IV.** 9

Шалгагч, тоологч нарын гүйцэтгэх ажил, үүрэг

**Бүлэг-V.** 17

Хүн ам, орон сууцны тооллогод зориулсан өрх, хүн амын бүртгэл

**Бүлэг-VI.** 20

Тооллогын хуудсыг нөхөх, түүний үнэн зөвийг шалгах

**Бүлэг-VII.** 62

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын материалыг хүлээн авах, явцын мэдээ болон урьдчилсан дүнг гаргах заавар

**Хавсралт** 73

## Бүлэг I. Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогыг явуулах эрх зүйн үндэс, шаардлага, зорилго, ач холбогдол

### а. Тооллогыг явуулах эрх зүйн үндэс

1. "Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн " Үндэсний статистикийн газар улсын хэмжээний хүн ам, орон сууцны тооллогыг 10 жил тутам ... удирдан явуулна" гэсэн заалт.

2. "Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас өөр хугацаанд тооллого явуулах зайлшгүй шаардлага гарвал Засгийн газар Улсын Их Хуралтай энэ талаар зөвшилцөн хугацааг нь тухай бүр тогтооно" гэсэн заалт.

3. "Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Албан ёсны статистикийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын ажилтан албан ёсоор мэдээлэх түвшинд хүрээгүй статистикийн мэдээлэл, судалгааны дүн, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нууцад хамаарах мэдээллийг нийтэд задруулахыг хориглоно" гэсэн заалт.

4. "Захиргааны хариуцлагын тухай" Монгол Улсын хуулийн 43 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Хүн ам, эд хөрөнгө, мал, тэжээвэр амьтан, аж ахуйн нэгжийн улсын тооллого явуулах, бүртгэх ажлаас зайлсхийсэн, эсхүл тооллого, судалгаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй, түүнчлэн эд хөрөнгө, мал, тэжээвэр амьтныг тооллогоос нуун даргадуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол холбогдох албан тушаалтан, иргэнийг 20000-100000 төгрөгөөр торгох шийтгэл ноогдуулна" гэсэн заалт.

5. "Хүн ам, орон сууцны улсын тооллого явуулах хугацааг зөвшөөрөх тухай" Монгол Улсын Их Хурлын 1998 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 06 дугаар тогтоол.

6. "Хүн ам, орон сууцны улсын тооллого явуулах тухай" Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 28 дугаар тогтоол.

7. "Комисс байгуулах тухай" Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 39 дүгээр тогтоол.

8. "Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын хуудсыг батлах тухай" Монгол Улсын Үндэсний статистикийн газар (ҮСГ)-ын даргын 1999 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 125 тоот тушаал, " Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын комисс, түр товчоодын ажлын удирдамж ", " Монгол Улсын хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого явуулах журам, тооллогын хуудас нөхөх заавар "-ыг (цаашид заавар гэнэ) батлах тухай Монгол Улсын ҮСГ-ын даргын 1999 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 171 тоот тушаал зэрэг нь тооллогыг явуулах эрх зүйн үндэс болно.

## б. Тооллого явуулах шаардлага, зорилго, ач холбогдол

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцаанаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж, улс орны нийгэм, эдийн засгийн байдал богино хугацаанд хурдан өөрчлөгдлөө.Төр, засгаас эдийн засаг, нийгэм, хүн амын талаар бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, сүүлийн жилүүдэд гарсан нийгэм-эдийн засгийн өөрчлөлтийг судлаж мэдэхэд хүн амын талаарх статистикийн дэлгэрэнгүй мэдээлэл зүй ёсоор шаардагдаж байна.

НҮБ-аас хүн амын тооллогыг наад зах нь 10 жилд нэг удаа явуулахыг гишүүн орнууддаа зөвлөмж болгосон байдаг. Энэ утгаараа манай улсад хүн амын ээлжит тооллогыг явуулах нь НҮБ-ын өмнө Монгол Улсын гишүүнийхээ хувьд хүлээсэн нэг үүрэг болж байгаа юм. Өнөөдөр дэлхийн олонх улс орнууд 2000-2001 онд хүн амын ээлжит тооллогоо хийхээр эрчимтэй бэлтгэж байна.

Монгол улс 20-р зуунд хүн амын тооллогыг нийтдээ 8 удаа, тухайлбал 1918, 1935, 1944, 1956, 1963, 1969, 1979, 1989 онуудад явуулсан юм.

**Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын (цаашид тооллого гэнэ) зорилго нь Монгол Улсын эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн байдалд сүүлийн 11 жилд гарсан өөрчлөлт, түүний шалтгаан, нөхцлийг судлах, дараагийн зууны эхний жилүүдийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг төлөвлөх, түүнийг хэрэгжүүлэх төр, засгийн бодлогыг боловсруулах, эрдэм шинжилгээ, судалгаанд**

**шаардлагатай статистикийн дэлгэрэнгүй тулгуур мэдээлэл бүрдүүлэхэд оршино. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаар баталсан "Төрөөс хүн амын талаар баримтлах бодлого"-ын хэрэгжилтийн эхний үеийн явцыг дүгнэх, цаашид уг бодлогыг боловсронгуй болгон тодорхойлоход шаардагдах статистикийн шинэ мэдээллийг цуглуулах, нэгтгэн дүгнэх нь ээлжит тооллогын бас нэг зорилт болно.**

Тооллогыг явуулснаар хүн амын тоо, нас, хүйсийн бүтэц, суурьшил, шилжилт, хотжилт, ажиллах хүч, ажил эрхлэлт, боловсрол, орон сууцны хангамж, нөхцөл зэрэг хүн ам, эдийн засаг, нийгмийн бусад олон шинж төрхийг агуулсан өргөн мэдээллийг цуглуулж түүнийг засаг захиргааны бүх нэгжээр боловсруулж гаргадгаараа хүн амын талаарх мэдээллийн бусад эх үүсвэрээс давуу талтай байдаг. Түүнчлэн Монгол Улсын гадаад харилцаа өргөжин хөгжиж, олон улсын байгууллагатай нягт хамтран ажилладаг болсон өнөө үед тэдгээрийг үнэн зөв тоо мэдээллээр хангахад тооллого нь чухал ач холбогдолтой юм.

Тооллого нь хүн амын талаарх статистикийн жил бүрийн мэдээ, тайлангийн үнэн, зөвийг шалгахад чухал ач холбогдолтой байх болно.

Энэ удаагийн тооллого нь Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжиж байгаа үеийн анхны тооллого болохын хувьд урьд өмнөх тооллогуудаас дараах хэдэн зүйлээр ялгагдах онцлогтой болно. Үүнд:

1.Тооллогын зарчим, ойлголтуудыг боловсруулахдаа НҮБ-ын удирдамж, зөвлөмжийг удирдлага болгосон тул олон улсын жишигт нийцсэн арга зүйгээр хийгдэнэ.

2.Хүн амын шилжих хөдөлгөөний талаар анх удаа мэдээлэл цуглуулах гэж байна.

3.Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн түүвэр судалгаагаар төрөлт, нас баралтын талаар мэдээлэл цуглуулсан учир ээлжит тооллогын асуулгад энэ талаарх мэдээллийн асуултыг оруулаагүй.

4.Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжиж байгаатай холбогдуулан ажил эрхлэлтийн байдлыг тодорхойлох аргачлал, арга зүйг олон улсын байгууллагынхтай нийцүүлэн боловсруулсан болно.

## Бүлэг II. Хүн ам, орон сууцны тооллогын тодорхойлолт, хугацааны тов, хамрах хүрээ

### а. Тодорхойлолт

**Хүн ам, орон сууцны тооллого** гэж товлон тогтоосон хугацаанд тухайн улс оронд (буюу түүний нутаг дэвсгэрийн тодорхой хэсэгт) оршин сууж байгаа бүх хүмүүсийн хүн ам зүй, эдийн засаг, нийгмийн байдал болон орон сууцны талаарх мэдээллийг цуглуулан авах, боловсруулах, үнэлэлт, дүгнэлт өгөх, хэвлэн нийтлэх, тархаах үйл ажиллагааны цогц мөн.

### б. Хүн амын тооллого явуулах хугацааны тов

Тооллогыг 2000 оны 1 дүгээр сарын 5-ны орон нутгийн өглөөний 8 цагаас эхэлж, 11-нийг дуустал, хяналтын тооллогыг 1 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн 3 хоногт багтаан явуулна. 2000 оны 1 дүгээр сарын 4-нөөс 5-нд шилжих шөнийн 24 цаг нь тооллогын хугацааны тов бөгөөд товоос хойш төрсөн хүүхдийг болон товоос өмнө нас барсан хүнийг тоолохгүй.

### в. Хамрах хүрээ

#### 1.Хүн амын тооллого

Тооллогод дараах хүмүүсийг хамруулна. Үүнд:

- Монгол Улсын нутаг дэвсгэрт тооллогын үед оршин суугаа Монгол Улсын иргэд,
- Монгол Улсын нутаг дэвсгэрт 183 хоногоос дээш хугацаатай сууж байгаа болон суухаар эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан гадаадын харъяат иргэд, харъяалалгүй хүмүүс,
- Тооллогын үед гадаадад оршин суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагад ажиллаж байгаа Монгол Улсын иргэд, тэдгээрийн гэр бүлийн гишүүд,
- Тооллогын үед гадаадад ажиллаж, суралцаж байгаа болон хувийн журмаар оршин суугаа Монгол Улсын иргэд.

## 2. Орон сууцны тооллого

Монгол Улсын нутаг дэвсгэрт болон гадаад оронд тоологдсон хүмүүсийн амьдардаг бүх төрлийн сууцыг хамруулна. Үүнд:

- Сууцны тусдаа байшин,
- Нийтийн сууцны байшин доторх сууц,
- Оюутан, сурагчдын дотуур байр,
- Ажилчдын нийтийн байр,
- Нийтийн эзэмшлийн бусад байр,
- Сууцны бус зориулалтын бусад байшин, байр,
- Бүх төрлийн гэр.

**Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогыг зохион байгуулах комисс, түр товчоод, байгууллага**



# Бүлэг III. Хүн ам, орон сууцны тооллого явуулах үндсэн зарчим, журам

## а. Хүн ам, орон сууцны тооллого явуулах үндсэн зарчим

Айл өрх, хүмүүсийн амьдарч байгаа орон сууцны байшин, гэр, нийтийн байранд (хоногийн ихэнх хугацаанд байрладаг) нь тоологч биеэр очиж, тооллогын хуудасны асуултад хариулт авах замаар хүн ам, тэдний орон сууц, түүний нөхцлийг хамтад нь бүртгэж тоолно.

## б. Хүн ам, орон сууцны тооллого явуулах журам

### 1. Хүн амын тооллого

Тооллогыг удирдан, зохион байгуулах Улсын комисс, ҮСГ-ын удирдлагын дор ҮСГ-аас баталсан удирдамж, заавар, маягтаар, аймаг, нийслэл, сум, дүүрэг, аймгийн төвийн сумын баг[1], хорооны тооллогын комиссууд зохион байгуулж явуулна.

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогыг зохион байгуулах комисс, түр товчоод, байгууллагын схемийг хавсаргав.

**а. Сум, аймгийн төвийн сумын баг, хорооны тооллогын комиссын тоологч нар:**

- Тооллогын үед эх орондоо байнга, түр суугаа, түр эзгүй байгаа Монгол Улсын (хугацаат цэргийн албан хаагчид, хоригдлоос бусад) бүх иргэд,
- Монгол Улсад 183 хоногоос дээш хугацаагаар оршин сууж байгаа болон суухаар эрх бүхий байгууллагаар зөвшөөрөгдсөн байнга болон түр суугаа, түр эзгүй байгаа гадаадын харъяат иргэд, харъяалалгүй хүмүүс,
- Тооллогын үед гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийг хугацаа харгалзахгүйгээр (гадаад улсад суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчдийн болон консулын газар, олон улсын байгууллагад ажиллагчид, тэдний гэр бүлийнхнээс бусад) үндсэн өрхөд нь түр эзгүйгээр тоолно.

[1] Аймгийн төвийн сумын баг нь тооллогын комисс, түр товчоог байгуулах бөгөөд харин хөдөөгийн сумын баг нь тооллогын комисс, түр товчоо байгуулахгүй.

**б. Гадаад харилцааны яам гадаадад суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагад ажиллаж байгаа Монгол Улсын иргэд, тэдний гэр бүлийн гишүүдийг тоолно.**

**в. Батлан хамгаалах яам жагсаалын цэрэг (хилийн цэргийг оруулаад)-ийг тоолно.**

**г. Хууль зүйн яам дотоодын цэрэг, хоригдол, цагдан хоригдогчид, урьдчилсан хорих байранд байгаа баривчлагдсан болон албадан саатуулагдсан хүмүүсийг тоолно.**

## 2. Орон сууцны тооллого

Тоологч нар тооллогод хамрагдаж байгаа бүх өрх, хүмүүсийн хоногийн ихэнх хугацаагаа өнгөрүүлдэг орон сууцны байшин, гэр, нийтийн байр, тэдгээрийн нөхцлийг бүртгэх замаар тоолно.

## Бүлэг IV. Шалгагч, тоологч нарын гүйцэтгэх ажил, үүрэг

### Шалгагч нарын гүйцэтгэх ажил, үүрэг

**Шалгагч нар тооллогын ажлыг хугацаанд нь чанартай, бүрэн хамралттай явуулахын тулд тоологч нарын ажилд хяналт тавьж, тооллогын хуудасны асуултын хариултын үнэн зөв байдлыг хангах, тоологч нараас тооллогын нөхсөн хуудсыг шалгаж хүлээн авах, урьдчилсан дүнг тогтоосон хугацаанд гаргах, хяналтын тооллогыг явуулах үндсэн үүрэгтэйгээр ажиллана.**

### а. Шалгагч нарын гүйцэтгэх ажил, үүрэг

1. Тооллогын сургалтад идэвхтэй оролцож, маягт, зааврыг сайн судлан мэдэж, тоологчийн гаргасан ямарч алдааг шалгаж олдог, зөв болгож засуулж чаддаг мэдлэг чадвар, дадлага эзэмшсэн байх,

2. Сум, аймгийн төвийн сумын баг, хорооны тооллогын комисс, түр товчооноос өгсөн удирдамж, зөвлөгөө, зааварчилгыг удирдлага болгон ажиллах,

3. Тооллогын комиссоос баталсан тооллогын зургийн дагуу тоологчид хүн амыг бүрэн хамруулж тоолж байгаа болон тооллогын хуудасны асуултад үнэн зөв хариулт авсан байдалд хяналт тавих,

4. Тооллогын комисс, түр товчооны дарга, гишүүдийн хамт өөрийн хариуцсан хэсгийн хил хязгаарыг тооллогын батлагдсан газрын зурагтай тулган шалгах, хэрэв зөрүүтэй байвал тодотгол хийж, сум, дүүрэг, баг, хорооны тооллогын комисст мэдэгдэн зохих шийдвэр авах, зэргэлдээх тооллогын хэсэгтэй хил хязгаараа маш нарийн тохиролцох,

5.Өөрийн хариуцсан хэсэгт байгаа зарим өрх айлаар (орон сууцны ба сууцны бус байшин, гэр, бусад газарт оршин суудгийг үл харгалзан) тооллогын зургийн дагуу орж, тухайн сууц, гэрт суугаа өрх, байнга суугаа хүмүүс, 6 сараас доош хугацаагаар түр суугаа, түр эзгүй хүмүүсийн нэрсийг тоологчийн хамт нэг бүрчлэн шалгаж, орхигдсон хүн байгаа эсэхийг тодруулах,

6.Тооллогын үед гэртээ эзгүй байж болзошгүй хүний судалгааг тоологч гаргасан эсэхийг шалгаж, тэднийг хэдийд яаж тооллогод хамруулах талаар тоологчид урьдчилан зөвлөгөө өгч зарим тохиолдолд баг, хорооны комиссоос нэгдсэн арга хэмжээ авахуулах,

7. Байшингийн дээвэр, орц, хонгил, дулааны шугам сүлжээний суваг, ой мод, уул хаданд амьдардаг хүмүүс байвал тэднийг тооллогод бүрэн хамруулахад онцгой анхаарч, тавих хяналтыг хүчтэй болгох,

8. Тоологч нар хүн амыг тооллогод бүрэн хамруулах зорилгоор хот, суурин газарт хүн амын хөдөлгөөнд ерөнхий хяналт тавьж тооллогын үед гарч болзошгүй төрөлт, нас баралт болон шилжих хөдөлгөөнийг ажиглаж, тэмдэглэж байгаа байдалтай танилцаж, энэ талаар баг, хорооны тооллогын комисстой байнгын холбоотой ажиллах,

9. Иргэдэд тооллогын зорилго, зарчим, журам, ач холбогдлыг сурталчлах ажилд идэвхтэй оролцох,

10. Тооллогын бэлтгэл ажлын шатанд болон тооллого явуулах, тооллогын материалыг хүлээн авах үед тоологчидтой ажиллах ажлын цагийн хуваарийг үе шатаар нь гаргаж, тооллогын комиссоор батлуулан тоологчдод танилцуулан түүнийгээ хатуу мөрдөн ажиллах,

11. Тоологч бүрт баталсан тооллогын газрын зургийг өгч, танилцуулах,

12. Тооллогын эхний 2 өдөр тоологчдын ажлын явцтай биечлэн танилцаж, зөвлөгөө өгөх, энэ өдрүүдийн эцэст тоологч бүрийн тооллогын хуудас нөхсөн байдалд нэг бүрчилсэн шалгалтыг заавал бүрэн хийж, алдаа гаргасан байвал засуулах бөгөөд цаашид алдаа гаргахгүй байх зааварчилгаагаар хангах, тооллогын явцад төв, суурин газрын шалгагчид, тоологч нарын тоолсон тооллогын хуудсыг өдөрт нь, хөдөө орон нутагт дараа өдөрт нь багтаан шалгаж байна. Хэрэв тоологч тооллогын хуудасны нөхөлтийн алдааг нь хэлж өгсөөр байхад дахин дахин алдаа гаргавал уг тоологчийг солих асуудлыг тооллогын комиссын даргад тавих,

13. Тооллогын эхний өдөр бүх тоологч ажилдаа гарсан эсэхийг шалгаж, хэн нэг нь ирээгүй бол шалтгааныг тодруулан

энэ талаар тооллогын комиссын даргад мэдэгдэж, зохих шийдвэр гаргуулах,

14. Тоологч бүр өдөрт дунджаар тооллогын хугацаанд тоолох нийт өрх, хүн амынхаа 15 хувийг тухайлбал, хөдөөд 4-5 өрх буюу 23-27 хүнийг, хот суурин газарт 10-12 өрх буюу 45-53 хүнийг тоолсон байх ёстой. Энэ нь тооллогын хамралт, явцыг хянахад хэрэгтэй юм. Гэхдээ 2000 оны 1-р сарын 8,9-ны хагас, бүтэн сайн өдөрт аль болох олон өрх айлаар орж тоолсон байхыг хичээх ёстой. Үүнд шалгагч нар өдөр бүр хяналт тавих,

15. Шалгагч нар нь өөрийн хариуцсан нутаг дэвсгэрийн хэдэн хүн тоологдсоныг нэгтгэн сум, баг, хорооны тооллогын түр товчоонд мэдээлж байх. Шаардлагатай гэж үзвэл тоологч нэмж авах талаар сум, баг, хорооны тооллогын комисст хүсэлт тавих,

16. Тооллогын хуудас нь хүн ам, орон сууцны улсын тооллогын үр дүнг нэгтгэн гаргахад ашигладаг үндсэн баримт болох тул нөхсөн тооллогын хуудсыг шалгахдаа зааврын дагуу цэвэр нямбай ажиллах,

17. Сум, дүүрэг, баг, хорооны тооллогын комиссоос явуулах шалгалтын тооллогод биечлэн оролцох,

18. Тооллогын өдөр тутмын ажлын зохион байгуулалтыг сайжруулах, тохиолдсон бэрхшээл, түүнийг арилгах талаар санал бодлоо тооллогын комисст илэрхийлэх,

19. Тооллогын хуудас, бусад маягтыг цэвэр нямбай, гэмтээхгүй хэрэглэх талаар тоологч нарт хяналт тавих,

20. Тооллогын урьдчилсан дүнг маягт УД-1, 2, 3, 4, 5 -аар гаргаж, сум, дүүрэг, баг, хорооны түр товчоонд тогтоосон хугацаанд өгөх,

21. Тооллогын хуудас, бусад маягтыг тоологч нарт нарийн тоолж хүлээлгэн өгөх бөгөөд тооллого дууссаны эцэст нөхсөн, нөхөөгүйгээр нь ялган тооллогын хуудас бусад маягтуудыг буцааж хүлээн авах, түр товчоотой тооцоо хийх,

22. Тооллогын хуудсанд бичигдсэн хариултыг 1997 онд батлагдсан "Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн (шинэчилсэн найруулга) 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, "Хувь

хүний нууцын тухай" Монгол Улсын хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу нууцлан хадгалах.

**б. Шалгагч нарт хориглох зүйлс**

1. Тооллогын хуудасны хариултыг сум, баг, хорооны тооллогын комисс, түр товчооны ажилтнуудаас бусад этгээдэд задруулах,
2. Нөхсөн тооллогын хуудсыг алдаж үрэгдүүлэх,
3. Тооллогын хуудсыг нугалах, үнгэх, урах, тасдах,
4. Цэнхэр, хөхөөс бусад (улаан, хар, ногоон гэх мэт) өнгийн тосон бал, харандаагаар тооллогын хуудсыг засах.

**Тоологч нарын гүйцэтгэх ажил, үүрэг**

**Тоологч нар сум, аймгийн төвийн сумын баг, хорооны тооллогын комисс, түр товчооны удирдлага, шалгагчийн өдөр тутмын хяналтын дор тооллогын бэлтгэл ажлыг бүрэн хангах, үүний дотор тоолох ёстой өрх, айл бүрийн тоологдох өрх, хүн амын бүртгэлийг нэг бүрчлэн гаргаж, тэднийг тооллогод бүрэн хамруулах, тооллогын хуудасны асуултыг чанартай, үнэн зөв нөхөх, тооллогын урьдчилсан дүнг тогтоосон хугацаанд нь гаргах үндсэн үүрэгтэйгээр ажиллана.**

**а. Тоологч нарын гүйцэтгэх ажил, үүрэг**

1. Тооллогын маягт, зааврыг урьдчилан сайн судлан мэдэж, зааврыг мөрдөн тооллогын хуудсыг нөхнө. Өөрийн ойлголтоор буюу заавраас өөрөөр дур мэдэн нөхөж болохгүй. Хэрэв ойлгомжгүй лавлах зүйл байвал шалгагч нараас асууж тодруулах, шаардлагатай гэж үзвэл сум, баг, хорооныхоо тооллогын комисс, түр товчооноос асууж тэдний зааврын дагуу ажиллах,

2. Тоологч нарын семинар, сургалтад идэвхтэй оролцож, тооллогын хуудас бусад баримт бичгийг бүрэн, үнэн зөв нөхөх, тоолуулагчтай зөв харьцаж, тооллогын хуудасны асуулт бүрт бүрэн хариулт авах талаар зохих дадлага туршлага эзэмшсэн байхын хамтад тооллогын хуудасны асуулт нэг бүрийн агуулга зорилгыг тоолуулж байгаа хүнд ойлгуулах мэдлэг чадвартай байх,

3. Тоологч өрх, хүн амын бүртгэл, тооллогын комиссын баталсан тооллогын газрын зургийн дагуу хүн ам, тэдний

суудаг байр, сууцыг тооллогод бүрэн хамруулан, тооллогыг графикт хугацаанд нь чанартай явуулах,

4.Өөрийн хариуцан тоолох хэсгийн хил хязгаарыг батлагдсан тооллогын газрын зурагтай тулган шалгах, хэрэв зөрүүтэй байвал шалгагчид мэдэгдэх, шаардлагатай гэж үзвэл баг, хорооны тооллогын комисст мэдэгдэж, зохих шийдвэр авах, зэргэлдээх тоологч нартай хил хязгаарын заагт орших өрхийг хэн тоолохоо маш нарийн тохиролцох,

5. Хот, суурин газрын тоологч тооллого эхлэхээс өмнө өөрийн хариуцсан хэсэгт байгаа өрх, айл бүрээр (орон сууцны ба сууцны бус байшинд, гэр бусад газар оршин суудгийг үл харгалзан) зургийн дагуу орж, тухайн сууц, гэрт байгаа өрхийн байнга, түр суугаа, түр эзгүй хүмүүсийн бүртгэлийг 2-оос доошгүй удаа очиж, дахин дахин шалгаж, зөрүүтэй зүйл байвал шалгагчид мэдэгдэх, шаардлагатай гэж үзвэл баг, хорооны тооллогын комисст мэдэгдэж тодруулах,

6. Байшингийн дээвэр, орц, хонгил, дулааны шугам сүлжээний суваг, ой мод, уул хаданд амьдардаг хүмүүс байгаа эсэхийг урьдчилан тогтоож, тэднийг тоолоход онцгой анхаарч, цагдаагийн байгууллагын туслалцаа авах эсэх асуудлыг шийдвэрлүүлсэн байх,

7. Хүн амын хөдөлгөөнд үргэлж хяналт тавьж, тооллогын үед гарч болзошгүй төрөлт, нас баралт болон шилжих хөдөлгөөнийг ажиглан тэмдэглэж, энэ талаар шалгагч, баг, хорооны тооллогын комисс, түр товчоонд мэдэгдэж шийдвэр авч байх,

8.Тоолохоор хариуцаж авсан хэсгийн нутаг дэвсгэрт байгаа эмнэлэг, зочид буудал, нийтийн байр гэх мэт хүмүүс нийтээрээ амьдардаг байрны оршин суугчдыг хэрхэн тоолох, ялангуяа тэдгээр байр сууцанд оршин суугчдыг тооллогод бүрэн хамруулах асуудлыг уг аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа, удирдлагатай нь нарийвчлан тохирох,

9.Тооллогын үед шөнийн ээлжийн ажилтай, мал эрэх, ан гөрөө хийхээр явсан, эмнэлэгт хэвтэж байгаа өвчтөнг 7 хүрэхгүй хоногоор сахиж байгаа болон бусад шалтгаанаар гэр орондоо түр байхгүй байх хүмүүсийг хэдийд тоолж болох боломжтой цаг хугацааг урьдчилан тохиролцож тогтоох,

10.Иргэдэд тооллогын зорилго, зарчим, журам, ач холбогдлыг сурталчилж, тоолох хугацааг тэдэнд урьдчилан мэдэгдэх, тооллогын хуудасны асуултад үнэн зөв хариулт өгөхөд бэлтгүүлэх,

11.Тооллогын хуудас, бусад маягтыг тооллогын түр товчооноос нарийн тоолж хүлээн авч, тооллого дууссаны эцэст нөхсөн, нөхөөгүйгээр нь ялган тооллогын хуудас, маягтуудыг анх хүлээж авсан тоотойгоо тохируулан баг, хорооны тооллогын түр товчоонд хүлээлгэн өгч тооцоо хийх,

12. Тооллогыг 2000 оны 1 дүгээр сарын 5-ны өглөөний 8 цагаас (орон нутгийн) олон хүнтэй, хөдөлгөөн ихтэй газраас эхлэн явуулах,

13.Тооллогыг хаанаас эхэлж, хаана дуусгахыг төлөвлөн тогтоосон графикийн дагуу явуулах, ингэхдээ тооллого явагдах графикт өдөрт эзэнгүй байх өрх, айл, хүн байвал хэдийд дахин очиж тоолж болохыг өдөр, цагаар тохиролцсон байх,

14. Тоологч нь өөрийн хариуцан тоолох нийт өрх, хүн амыг 7 хоногийн хугацаанд бүрэн тоолж амжихаар тооцоолж ажиллах,

15. Тооллогын хуудас нь хүн ам, орон сууцны улсын тооллогын үр дүнг нэгтгэн гаргахад ашигладаг үндсэн баримт болох тул тоологч тооллогын хуудасны асуултын хариултыг заврын дагуу үнэн зөв, цэвэр нямбай нөхсөн байх,

16. Шалгагчийн тогтоосон өдөр, цагт тооллогын комисс, түр товчооны ажлын байранд ирж, нөхсөн тооллогын хуудсуудаа шалгуулан алдаа байвал тооллогын хуудсанд хэвлэгдсэн тоо, нүдний хүрээг арилгахгүйгээр засварыг заврын дагуу гаргацтай, цэвэр хийх, алдааг засахад хариулсан эзэнтэй нь уулзах шаардлага гарвал дахин очиж, зөв болгож байх,

17. 2000 оны 1-р сарын 5, 6 буюу тооллогын эхний 2 өдрийн тооллогын хуудас нэг бүрийн нөхөлтийг шалгагчтай хамтран шалгаж, гаргаж байгаа алдаагаа дараагийн өдрүүдэд гаргахгүй байхаар ойлгож, мэдэж авсан байх,

18. Хэрэв тооллого явагдахын өмнө, эсхүл тооллого явагдаж байх хугацаанд зайлшгүй шаардлагаар гадаадад

болон өөр засаг захиргааны нэгжид явах хүмүүс гарвал урьдчилан тоолж, **"Гэрчилгээ"** олгох,

19. Тоологдсон 15-аас дээш насны хүн бүрт **"Гэрчилгээ"** олгоно. Энэ **"Гэрчилгээ"**-г 2000 оны 1 дүгээр сарын 15-ныг дуустал биедээ авч явах, тооллогын ажилтнуудын хүсэлтээр тэдэнд үзүүлж байхыг тоолуулагчид анхааруулан хэлж байх хэрэгтэй,

20.Тооллогын өдөр тутмын ажлын зохион байгуулалтыг сайжруулах, тохиолдсон бэрхшээл, түүнийг арилгах талаар санал бодлоо тооллогын комисст илэрхийлэх, тооллогыг хугацаанд нь багтаан бүрэн дуусгах талаар идэвх санаачлагатай ажиллах,

21. Тооллогын хуудсыг цэвэр нямбай, гэмтээхгүй хэрэглэхийн зэрэгцээгээр нөхсөн тооллогын хуудас, бусад маягтуудыг тоос, шороо, ус нэвтрэхгүй зүйлээр дөрвөн талаас нь ороож, тусгай бэлдсэн хавтсанд хадгалах,

22. Тооллогын урьдчилсан дүнг маягт УД-1, 2, 3, 4, 5-аар өрх нэг бүрээр гаргаж, шалгагчид тогтоосон хугацаанд өгөх,

23. Тооллого дууссаны эцэст баг, хорооны тооллогын комисст ажлаа тайлагнаж, дүгнүүлэх.

### б.Тоологчийн баримтлах зарчим

1. Тооллогын хуудсанд бичигдсэн хариултыг 1997 онд батлагдсан "Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн (шинэчилсэн найруулга) 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, "Хувь хүний нууцын тухай" Монгол Улсын хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу нууцлан хадгалах,

2. Тооллогын хуудасны хариултыг нөхөхдөө хувь хүнээс ямар нэг албан ёсны баримт бичиг шаардахгүйгээр харилцан ярилцаж, асуух замаар хариултыг авах, хэрэв тухайн хүн өөрөө сайн дураараа баримт бичгээ үзүүлбэл түүнийг тооллогын хуудасны нас, боловсрол, гэрлэлтийн байдал зэрэг асуултын хариултыг нөхөхөд ашиглаж болно. Тоолуулж байгаа гадаадын иргэн Монгол Улсад оршин суух хугацаагаа хэлж мэдэхгүй байвал түүний иргэний паспорт, Монгол Улсын Хөдөлмөр зохицуулалтын газар, Гадаадын хөрөнгө оруулалтын газраас олгосон үнэмлэхийг үзэж болно,

3. Хүн амыг тоолохдоо тооллогын асуулт бүрийн учир утгыг тоолуулж байгаа хүнд ойлгуулан, хариулт авахдаа яаруулж тэвдүүлэлгүй, хариулагчаа татгалзах байдалд хүргэхгүйгээр үргэлж эелдэг харилцаж, тэлөв даруу, төвийг сахисан байх,

4. Баг, хорооны тооллогын комиссоос олгосон тооллогын тоологчийн үнэмлэхийг биедээ үргэлж авч явж, тоолуулагчид үзүүлж байх,

5. Тооллогын хуудсыг зөвхөн цэнхэр, хөх энгийн тосон балаар нөхөх.

**в.Тоологчийн хориглох зүйлүүд**

1.Тооллогын хуудасны хариултыг баг, хорооны тооллогын комисс, түр товчоо, шалгагч нараас бусад хүнд үзүүлэх, задруулах,

2. Нөхсөн тооллогын хуудсыг алдаж үрэгдүүлэх,

3.Тооллогын хуудсыг нугалах, үнгэх, урах, тасдах,

4.2000 оны 1 сарын 4-нөөс өмнө өрх, хүн амыг тоолох, (тоологч нарын гүйцэтгэх ажил, үүргийн 18-д заасанаас бусад тохиолдолд)

5.Цэнхэр, хөхөөс өөр (улаан, хар, ногоон гэх мэт) өнгийн тосон бал, харандаагаар тооллогын хуудсыг нөхөх.

## Бүлэг Y. Хүн ам, орон сууцны тооллогод зориулсан өрх, хүн амын бүртгэл.

Тооллогод зориулж өрх, хүн амын бүртгэлийг 1999 оны 12-р сарын 15-наас 22-ны дотор сум, дүүрэг, баг, хорооны тооллогын комисс, түр товчоо орон нутгийн төр, засгийн байгууллагатай хамтран зохион байгуулж хийнэ. Энэ бүртгэл нь баг, хороонд жил бүр хөтлөгдөж байгаа суурин хүн амын бүртгэлээс эрс ялгаатай бөгөөд 1999 оны 12 сарын байдлаар гаргасан байх ёстой.

### а. Хүн ам, орон сууцны тооллогод зориулсан өрх, хүн амын бүртгэл гаргах журам.

1. Бүртгэлийг бүх баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд хийнэ. Тухайн орон нутгийн засаг захиргааны суурин хүн амын бүртгэлд байдаг эсэхийг харгалзахгүй нутаг дэвсгэрийн хилийн дотор̆х (цаг агаарын хүндрэлийн улмаас өөр сум, хорооноос тус сум, хорооны нутагт олноороо өвөлжиж байгаа болон отор хийж байгаа айл өрхөөс бусад )[3] бүх өрх, хүн амыг тэдний сууж байгаа сууцны хамт бүртгэнэ.

Бүртгэлийг **Маягт ХАОСТ-3-аар** гаргана. Энэ маягтын үзүүлэлтийг нэмж, хасч, өөрчилж хэрхэвч болохгүй. Энэ бүртгэл зөвхөн хүн ам, орон сууцны тооллогод зориулсан учраас тухайн орон нутгийн засаг захиргааны суурин хүн амын бүртгэлээс зөрүүтэй байж болно. Тооллогын бэлтгэл ажлын шатанд иргэдийн орон нутгийн засаг захиргааны харъяаллыг заавал шийдсэн байх хэрэгтэй. Мөн зарим үед нэг өрх тасарч тоологдох тал байж болно. Жишээлбэл, сургуулийн хүүхдүүд эцэг, эхийнхээ аль нэгтэй буюу хамаатан садантайгаа сумын төвд сууж байвал (сургуулийн дотуур байрнаас гадуур) өрх үүсгэж бүртгэгдэх тал гарч болохыг үгүйсгэхгүй .

2. Өрх, хүн амыг бүртгэхдээ аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутгийн хилийн зааг байгаа өрх, хүн амыг орхигдуулахаас сэрэмжилж, хил залгаа аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны засаг захиргааны байгууллага, тооллогын комисс харилцан уялдаатай ажиллах шаардлагатай.

3. Тухайн үеийн цаг агаарын байдлаас шалтгаалан өөрийн харъяалагдах засаг захиргааны нутаг дэвсгэрээс өөр

---

[3] Тухайн сум, хорооны нутагт өөр сум, хорооноос ганц нэгээрээ өвөлжиж байгаа болон отор хийж байгаа айл, өрхүүдийг бүртгэж тоолно.

газарт түр хугацаагаар олноороо өвөлжиж байгаа болон отор хийж байгаа айл өрх, хүн амын бүртгэлийг үндсэн захиргаа нь очиж хийнэ.

4. Ямарч гэр оронгүй, байшингийн дээвэр, орц, хонгил, дулааны шугам сүлжээ, ой мод, уул хаданд амьдрагчдыг нэг бүрчлэн илрүүлж, хаана бүртгэхээ шийдвэрлэж, дараа нь тооллогод хамруулах арга хэлбэрийг эртнээс сайтар боловсруулан тогтоох хэрэгтэй.

5. Сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт байрлаж байгаа оюутан сурагчдын дотуур болон ажилчдын нийтийн байранд суугчдыг бүртгэхийн хамтад амралт сувилал, эмнэлэг, зочид буудал зэрэг газруудад судалгаа явуулж, тооллогын үед хэдэн хүн ямар хугацаатай байрлаж байж болохыг урьдчилан тодруулсан байх шаардлагатай.

**6. Өрх, хүн амын бүртгэлийн Маягт ХАОСТ-3-ыг нөхөх заавар**

Бүртгэлийн маягтыг нөхөхдөө **1-р баганад** тухайн баг, хорооны нутаг дэвсгэрт байгаа тооллогод хамрагдах сууцны байшин, гэр, нийтийн байрыг нэгээс эхлэн дугаарлаж бичнэ. **2-р баганад** сууцны төрлийг "байшин", "гэр", "нийтийн байр" гэж бичнэ. **Байшин:** сууцны зориулалтын, сууцны бус зориулалтын, иргэдийн өөрсдөө барьсан сууцыг ялгахгүй бүгдийг байшин гэж үзнэ. Тооллогын үед тэдгээр байшинг зориулалтаар нь ялган салгаж тоолох учир иймхүү урьдчилсан бүртгэлийг хийж байгаа болно. **Гэр:** бүх төрлийн гэрийг түүний ханын тоог нь харгалзахгүйгээр бүртгэнэ. Цаатангуудын урцыг гэрт хамруулна. **Нийтийн байр:** ажилчид, оюутан, сурагчид болон бусад нийтээр суух байрыг ялгахгүйгээр нийтийн байр гэж үзнэ. Мөн цэргийн хүрээ, хорих газар, урьдчилан болон цагдан хорих байрыг нийтийн байр гэж үзнэ. **Бусад:** Хүн байрладаг дээрхээс бусад газрыг бусад гэж бүртгэнэ. **3-р баганад** сууцны байшин, гэр, нийтийн байранд сууж байгаа өрхийг эхнээс нь дугаарлаж, (хэрэв нийтийн байр бол өрөө тасалгаагаар нь дугаарлана) түүний хаягийг, "хаяг" гэсэн баганад байшин, хашаа, хаалганы эсхүл өрөөний дугаарыг оруулан тодорхой бичнэ. **4-р баганад** тухайн өрх, гэр бүл болон нийтийн байрны өрөө, тасалгаанд амьдарч байгаа хүмүүсийг эхнээс нь эхлэн дугаарлана. **5-р баганад** өрхийн гишүүдийг өрхийн тэргүүлэгчээс нь эхлэн дараа нь эхнэр буюу нөхрийг, дараа нь хүүхэд, бусад садан төрлийн хүмүүсийн овог, нэрийг бичиж, өрхийн тэргүүлэгчтэй хамааралгүй

хүмүүсийн овог, нэрийг хамгийн сүүлд бичнэ. **Нэг өрхийн ам бүлийн гишүүдийн овог, нэрийг бичиж дуусаад доогуур нь зурж өөр өрхийнхийг бичнэ. 6-8-р баганад** тухайн сууцны байшин, гэр, нийтийн байранд суугчдын суурьшлыг бүртгэл хийж байгаа үеийнхээр **"байнга суудаг"** , **"түр суугаа"**, **"түр эзгүй"** гэж ангилан " **+** " тэмдэг тавина. **9-р баганад** тухайн нутагт түр суугаа хүний байнга суудаг, түр эзгүй хүний түр сууж байгаа аймаг, нийслэл, сум, дүүрэг, гадаадад явсан бол аймаг, нийслэлийн оронд оршин сууж байгаа улсын нэрийг, сум, дүүргийн оронд тухайн хүний амьдардаг хотынх нь нэрийг тус тус бичнэ. Энэ бүртгэлийг гаргаснаар тооллогод тухайн сум, баг, хорооны нутаг дэвсгэрт хэдэн өрх, хүн ам, ямар төрлийн сууцны хамт тоологдохыг нэг бүрчлэн тодорхойлох болон тоологч, шалгагчдад тооллого явуулах нутаг дэвсгэр, хүн амыг нь тодорхой хуваарилан өгөх боломжийг бүрэлдүүлнэ.

Мөн түүнчлэн тооллогод зориулсан газрын зургийг нарийвчлан тодотгох үндэслэл болно.

# Бүлэг VI. ТООЛЛОГЫН ХУУДСЫГ НӨХӨХ, ТҮҮНИЙ ҮНЭН ЗӨВИЙГ ШАЛГАХ

## а. Тооллогын ажлыг эхлэх

**Тоологч нар өрх, хүн амыг тоолохдоо айлын хаалгыг тогшиж, эелдгээр мэнд ус асууж, үнэмлэхээ үзүүлж, хүн ам, орон сууцны тооллогын ажлаар яваа зорилгоо танилцуулна.**

**Тоологч хүн ам, орон сууцны тооллогын хуудасны асуултуудыг нөхөхдөө өрхийн тэргүүлэгч болон 16 ба түүнээс дээш насны хүн бүрээс асууж нөхнө. Харин 16-аас доош насны хүүхдийнхийг өрхийн тэргүүлэгчээс асууж нөхнө. Түр эзгүй буюу тухайн өрхийн байнга оршин суугч нь тооллого явагдах тэр мөчид гэр орон байрандаа байхгүй байгаа тохиолдолд өрхийн тэргүүлэгчээс нь, өрхийн тэргүүлэгч эзгүй байвал өрхийн насанд хүрсэн аль нэг гишүүнээс асууж нөхнө. Нийтийн байр сууцанд өрх үүсгэхгүй тоолуулж байгаа (ураг төрлийн болон гэр бүлийн холбоогүй) хүмүүсийн хувьд тооллогын хуудасны асуултыг хүн нэг бүрээс асууж нөхнө.**

**Тооллогын хуудсыг нөхөхдөө дараах зүйлийг баримтална.**

1. **Өрх, түүнд тоологдсон хүн.** Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэж үзэж, тэнд байнга суугчид (түр эзгүй хүн ороод), түр суугаа хүмүүсийг өрхөд тоологдсон хүн гэж үзнэ.

Тооллогын үед тухайн өрх айлд гишүүдээс нь гадна өрхийн ам бүлд орохгүй садан төрлийн хүмүүс болон ураг төрлийн буюу гэр бүлийн холбоогүй хүмүүс амьдарч байвал тэднийг уул өрхөд тоолно.

Өрхийн ам бүлээс хугацаат цэргийн алба хааж байгаа, өөр аймаг, нийслэлд суралцаж байгаа оюутан, сурагчид, албадан саатуулагчид (72 цагаар), урьдчилан хорих байранд баривчлагдагчид (1 сар хүртэл хугацаагаар), цагдан хоригдогчдыг ар гэрт нь тоолохгүй. Үндсэн засаг захиргааныхаа нэгжээс өөр сум, аймаг, нийслэлд суралцаж буй хүмүүс нь 6 сараас илүү хугацаагаар тэндээ амьдарч байгаа тул оршин сууж байгаа газарт нь байнга суугаагаар тоолно. Харин цэрэг, хоригдол, оюутан, сурагчид тооллогын

үед гэртээ чөлөөгөөр буюу амралтаараа ирээд байгаа бол гэрт нь байнга суугчаар тоолно. Ийм учраас тоологч, тоолуулж байгаа өрхийн ам бүлийн гишүүдтэй сайтар харилцан ярилцаж, энэ хэсгийн эхэнд байгаа тодорхойлолтыг үндэслэн өрхөд тоологдох хүнийг тогтоож, өрх бүрт тооллогын хуудас нээнэ. Тэгэхдээ хэн хэн нь өрхийн ам бүлийн гишүүд, түр эзгүй байгаа, түр сууж байгаа хүн байгаа эсэхийг тодруулж, тэр өрхөд тоологдох хүний тоог яг тогтоосны эцэст тооллогын хуудсанд өрхийн тэргүүлэгчийн эцгийн (эхийн) нэр, өөрийнх нь нэрийг эхлээд бичиж, дараа нь бусад бүх хүнийхийг бичсэний дараа тоолох ажилдаа орно.

2. Тооллогын хуудас нээхдээ тухайн өрхийн сууж байгаа орон-сууцны төрөл хэлбэрийг нь харгалзан үзэхгүй. Нэг сууц, гэрт хэд хэдэн өрх амьдарч болохоос гадна оюутан, сурагчдын дотуур болон ажиллагчдын нийтийн байр, бусад байранд ч өрх амьдарч байж болно.

3. **Тооллогын үед нэг орон сууц, байранд хамт амьдарч байгаа боловч ураг төрлийн болон гэр бүлийн холбоогүй хүмүүсийг өрх гэж үзэхгүй.** Эдгээр хүмүүсийг хамтад нь тооллогын нэг хуудас, үргэлжлэл хуудас ашиглан тоолно. Энэ тохиолдолд хүмүүсийн амьдарч байгаа өрөө тасалгаа тус бүрт нь тооллогын хуудас нээж, тооллогын хуудасны нүүрний хэсгийн "нийтийн болон бусад байр-3"-ыг дугуйлна. Үүнд дараах тохиолдлууд байж болно.

а. Оюутан сурагчдын дотуур болон ажиллагчдын нийтийн байр, цэргийн хүрээ, эмнэлэг, сувилал, асрамжийн газарт нэг өрөө тасалгаанд хамт амьдарч байгаа ураг төрлийн болон гэр бүлийн холбоогүй хүмүүс,

б. Барилгын дээвэр, хонгил, орц, дулааны шугам сүлжээний суваг, ой мод, уул хад зэрэгт байрлаж байгаа гэр бүлийн болон ураг төрлийн холбоогүй хүмүүс,

в. Айлын сууц буюу сууцны нэг хэсгийг хөлслөн сууж байгаа ураг төрлийн болон гэр бүлийн холбоогүй хүмүүс. Энэ тохиолдолд тооллогын хуудасны "байр, орон сууцны төрөл нөхцөл"-ийн "зориулалт" гэсэн 02-р асуултын хариултуудаас аль тохирохоор нь нөхнө.

4.Тооллогын нэг хуудсанд 6 хүнийг тоолохоор байгаа. Хэрэв тухайн өрх, бусад нийтийн байр сууцанд 6-аас илүүгүй хүнтэй бол тухайн өрх, байр сууцанд суугчдын хүн амтай холбогдох асуултыг нөхөж дуусаад тооллогын хуудасны доод талд байгаа "Үргэлжлэлтэй юу?" гэсэн асуултын арын "үгүй-2"

гэснийг дугуйлж, тооллогын хуудасны арын нүүрэнд байгаа байр орон сууцны төрөл, нөхцлийн асуултад шилжинэ. Хэрэв 6-аас илүү хүнтэй байвал тооллогын хуудасны доод талд байгаа "Үргэлжлэлтэй юу?" гэсэн асуултын "Тийм-1" гэснийг дугуйлна. Өрх, нийтийн байранд тоологдож байгаа хүний тооноос хамаарч Үргэлжлэл-1, Үргэлжлэл-2-ын аль тохирохыг хэрэглэнэ. Өрх, нийтийн байрны өрөө тасалгаанд 10-аас илүүгүй хүн тоолуулбал Үргэлжлэл-1-ийг нээж, тоолуулагчийн дэс дугаарыг 07-оос эхэлж дугаарлана. Өрх, нийтийн байрны өрөө тасалгаанд 11 ба түүнээс дээш хүн тоолуулбал Үргэлжлэл-2-ыг нээж, тоолуулуулагчийн дэс дугаарыг мөн 07-гоос эхлэн дугаарлана.

## 6. Тооллогын хуудсыг нөхөхөд баримтлах нийтлэг зүйл

1.Тоологч тооллогын хуудасны асуултын дэс дараалаар тоолуулагчаас асууж, хариултыг тэмдэглэнэ.

2. Тооллогын хуудасны бүх асуултын хариулт нь олон хувилбартай байгаа. **Тоолуулагч тэдгээрээс асуулт тус бүрт өөрт тохирох зөвхөн нэг нэг хариулт өгөх ёстойг тоологч анхаарах хэрэгтэй. Хэрэв нэг асуултад олон хариулт хэлбэл тоолуулагчаас дахин асууж аль зөвийг нь үлдээнэ.**

3. Тооллогын хуудасны асуултад тоолуулагчийн өгсөн хариултыг тэмдэглэхдээ ихэнх тохиолдолд асуултын хариултын арын холбогдох кодыг дугуйлна. Тооллогын хуудасны хариултын кодыг зөв газар нь тэмдэглэсэн эсэхээ тоологч байнга хянана. Өөрөөр хэлбэл тоологч хариултыг дугуйлахдаа туйлын анхаарал болгоомжтой хандан, уул кодын дээр буюу доор , эсвэл хажууд нь байгаа кодыг давхар дугуйлахгүй байх хэрэгтэй.

Өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох гэсэн 1-р асуултын хариултыг тэмдэглэхдээ өрхийн тэргүүлэгч хүнийхийг бол зөвхөн 01 гэсэн кодыг дугуйлна. Жишээ нь:

| **1. Өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох** | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тэргүүлэгч өөрөө | -01 | Эгч/ ах / дүү | -05 | Ач . зээ | -09 | (01) | 05 | 09 |
| Эхнэр/ нөхөр | -02 | Хадам эх/ эцэг | -06 | Бусад төрөл төрөгсөд | -10 | 02 | 06 | 10 |
| Охин/ хүү | -03 | Бэр/ хүргэн | -07 | Хамааралгүй | -11 | 03 | 07 | 11 |
| Эх/ эцэг | -04 | Эмэг эх/ өвөг эцэг | -08 | | | 04 | 08 | |

Боловсрол гэсэн 11-р асуултын хариултыг бөглөхдөө бүрэн дунд боловсролтой хүний хувьд зөвхөн 3 гэсэн кодыг дугуйлж бусдыг үлдээнэ.

Жишээ нь:

| **11. Боловсрол** | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Боловсролгүй | -1 | Бүрэн дунд | -4 | Тусгай мэргэжлийн | | 1 | 4 | 6 |
| Бага | -2 | Техник | | дунд (бүрэн бус дээд) | -6 | 2 | 5 | 7 |
| Бүрэн бус дунд | -3 | мэргэжлийн | -5 | Дээд | -7 | (3) | | |

4. Тооллогын хуудасны зарим хариултад он, сар, улс, аймаг, нийслэлийн нэр, кодыг бичихээр байгаа. Энэ тохиолдолд тоологч **кодыг** зааврын холбогдох хавсралтаас харж үнэн зөв бөглөх хэрэгтэй. Асуултын хариултыг үгээр бичих тохиолдолд ялангуяа тооллогын хуудасны 16,17 -р асуултын хариултыг бичихдээ маш гаргацтай, цэвэр нямбай, товч тодорхой бичих бөгөөд код тавих дөрвөлжин нүхнүүдэд үг үсэг оруулан бичиж болохгүй.

5. Код бичих зориулалтын дөрвөлжин нүдэнд тоог нэг нэг оронгоор нь маш гаргацтай бичнэ. Нүдэнд тавигдах тооны оронгийн тоо нь нүдний оронгийн тооноос бага байвал өмнө нь "0" тавьж урагш нь гүйцээж бичсэн байх ёстой байна. Жишээ нь:

| 0 | 1 |, | 0 | 0 | 1 |, | 0 | 0 | 0 | 1 | болон | 0 | 1 | 2 |, | 0 | 1 | 2 | 0 | гэх мэт.

6. Тооллогын хуудасны зарим хариултаас доош нь "сум" заасан байгаа. Энэ нь тоолуулагч тэр "сум" заасан асуултад тохирох хариулт өгвөл, " сум " заасан дараагийн асуулт руу шилж гэсэн үг юм. Жишээ нь **Суурьшил** гэсэн 7-р асуултад тоолуулагч байнга суудаг гэж хариулсан тохиолдолд тоологч 1 гэсэн кодыг дугуйлж, шууд 8-р асуултыг асуух хэрэгтэй.

Мөн боловсрол гэсэн 11-р асуултад тоолуулагч ямар нэг шатны боловсролтой гэж хариулсан тохиолдолд тоологч 2-7-р кодын аль нэгийг дугуйлж, 13-р асуултыг асуух хэрэгтэй.

7. Тооллогын хуудасны асуултын хариултыг буруу тэмдэглэсэн тохиолдолд уг хариултыг **"Х"** тэмдгээр дарж зөв кодыг дугуйлна.

**11. Боловсрол**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Боловсролгүй | -1 | Бүрэн дунд | -4 | Тусгай мэргэжлийн | |
| Бага | -2 | Техник | | дунд (бүрэн бус дээд) | -6 |
| Бүрэн бус дунд | -3 | мэргэжлийн | -5 | Дээд | -7 |




8. Хэрэв тоолуулагчийн хариулт эргэлзээтэй санагдвал тоологч
тэр дор нь лавлан асууж зөв болгоно.

9. Нэг хүнээс тооллогын хуудасны бүх асуултыг асууж дуусcаны дараа тооллогын хуудсанд бичигдсэн дараачийн хүнээс асууж эхэлнэ.

## в. Тооллогын хуудасны нүүрэн талын асуултыг нөхөх тухай

**1. Тооллогын комиссын дугаар.** Үндэсний статистикийн газраас аймаг, нийслэл, сум, дүүрэг, аймгийн төвийн сумын баг, хорооны нэрээр хүргүүлсэн комиссын дугаарыг бичнэ.

**2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр.** Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо гэсэн асуултад тухайн аймаг, нийслэл, түүний сум, дүүрэг, баг, хорооны нэрийг бичиж, аймаг, нийслэл, сум, дүүргийн кодыг энэ зааврын Хавсралт-1-ээс харж арын дөрвөлжин нүдэнд бичнэ. Аймаг, нийслэлийн нэрийг бичихдээ Архангай, Дорнод, Улаанбаатар гэх мэт, сум, дүүргийнхийг Батцэнгэл, Сэргэлэн, Сүхбаатар гэх мэт албан ёсны нэрийг бичнэ. Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэрийг бичихдээ код тавих зориулалтын дөрвөлжин нүдэнд оруулан бичиж болохгүй.

**3. Тосгоны нэр.** Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай Монгол улсын хуульд зааснаар 500-15000 оршин суугчидтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг нь хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газарт оршин суугчдыг тосгоны хүн амд хамруулна. Тоолуулагчийн оршин суугаа газар нь хуулийн дээрх заалтын дагуу тосгонд хамаарагддаг бол тосгоны албан ёсны нэрийг бүтнээр нь бичнэ. Тосгоны кодыг Хавсралт-2-оос харж бичнэ.

**4. Байршил.** Хүн амыг тооллогын үед оршин суугаа байршлаар нь нийслэл, аймгийн төв, тосгон, сумын төв, хөдөө

гэж тав ангилж, тохирох кодыг нь арын дөрвөлжин нүдэнд бичнэ.

**5. Тоологчийн дугаар.** Тухайн тооллогын комиссоос тоологч бүрт өгсөн дугаарыг бичнэ.

**6.Тооллогын хуудасны дугаар.** Тооллогын хуудасны дугаарыг тухайн тоологч эхний өрхөөс (нийтийн байрны эхний өрөө тасалгаанаас) эхлэн 001, 002, 003 гэх мэт дараалуулан дугаарлана. Зургаагаас дээш ам бүлтэй өрх айлд 2 болон түүнээс олон үргэлжлэл хуудас нөхөгдвөл тэдгээрийн дугаар нь үндсэн хуудасны дугаартай ижил байна.
Нийтийн байр сууцны тус тусдаа өрөө тасалгаанд суугчдын тооллогын хуудасны дугаар өөр өөр байна.

**7.Гудамжны нэр.** Тоологдож байгаа өрх /нийтийн байр, сууц/ болон хүний амьдарч байгаа гудамжны албан ёсны нэрийг товчлолгүйгээр бичиж, арын дөрвөлжингүүдэд дугаарыг нь бичнэ. Жишээ нь "Энхтайван" , "Уурхайчин" гэх мэт.

**8. Байшин, сууц, хашааны дугаар.** Тухайн өрх, нийтийн байр, байшин, сууцны болон хашааны дугаарыг зориулалтын дөрвөлжин нүдэнд орон оронгоор нь салгаж маш гаргацтай бичнэ. Сууцны дугаар гэдэгт орон сууцанд амьдардаг өрхийн хаалганы дугаарыг ойлгоно. Гэр хорооллын хувьд гудамж, хашааны хаалганы дугаарыг нөхнө.

**9. Сууц эзэмшигч өрх**. Тоологч тухайн сууц (гэрт)-анд хэдэн өрх сууж байгааг асууж, 2 буюу түүнээс дээш тооны өрх айл сууж байвал сууц эзэмшигчээс эхэлж тоолно. Сууц эзэмшигч өрхийн хувьд " 1" гэсэн кодыг дугуйлна. Гэхдээ сууц эзэмшигч өрхөд аль өрхийг хамруулахыг тухайн орон сууц, гэр, байранд оршин суугчид өөрсдөө сайн дурын үндсэн дээр шийдвэрлэнэ. Айл өрхүүд сууц эзэмшигчээр аль өрхийг тоолуулахаа шийдэж чадахгүй бол тухайн сууцанд хамгийн удаан амьдарсан буюу олон ам бүлтэй, эсвэл өрхийн тэргүүлэгч нь насаар ахмад зэргийг харгалзан тогтоож болох юм. Тэгэхдээ энэ нь сууцны хууль ёсны эзэмшилтэй холбоогүй гэдгийг суугчдад дахин анхааруулах хэрэгтэй.

Хүн ам, орон сууцны тооллогод сууц эзэмшигч өрх, хамтран сууж байгаа өрх гэж тооллогын хуудсыг нөхөх нь уул сууцны цаашдын эзэмшилд нөлөөлөхгүй зөвхөн тооллогын үед сууцны талбай болон бусад үзүүлэлтийг давхардуулан

тоолохгүй байхад зориулагдсаныг иргэдэд сайтар ойлгуулах хэрэгтэй.

**10.Тухайн сууцанд хамтран суугч өрх.** Сууц (гэр) эзэмшигчээс бусад өрхийн хувьд 2 гэсэн кодыг дугуйлна.

**11. Нийтийн болон бусад байр.** Оюутан, сурагчдын дотуур болон ажиллагчдын нийтийн байр, цэргийн хүрээ, асрамж, тэтгэмжийн газар, эмнэлэг, байшингийн дээвэр, хонгил, орц, дулааны шугам сүлжээний суваг, ой мод, уул хад зэрэг газарт өрх үүсгэхгүй оршин суугчдын хувьд тооллогын хуудсанд 3 гэсэн кодыг дугуйлна.

**12. Тоологдсон хүний тоо.** Тоологдсон хүний тоог тухайн өрхийн тооллогын бүх хуудсанд (үргэлжлэл ороод) бичигдсэн хүний тоогоор бичнэ. Жишээ нь өрхөд 8 хүн тоологдсон байхад тооллогын үндсэн хуудсанд 6 хүн, үргэлжлэл хуудсанд хоёр хүн тоологдоно. Иймэрхүү тохиолдолд уг өрхийн (нийтийн байрны) тооллогын үндсэн хуудасны тоологдсон хүний тоо гэдэгт 8 гэж бичнэ. Нийтийн байрны нэг өрөөнд олон хүн сууж байвал хэд хэдэн үргэлжлэл хуудас дамжуулан нөхөх бөгөөд үндсэн хуудсанд тэр өрөөнд тоологдсон бүх хүний тоог бичнэ.

**13.Тооллогын хуудасны тоо.** Тухайн өрх (нийтийн байрны нэг өрөө)-д тоологдсон хүний тооноос хамаарч тооллогын үндсэн хуудаснаас гадна хэд хэдэн үргэлжлэл хуудас нөхөгдөж болно. Энэ тохиолдолд тухайн өрх (нийтийн байрны нэг өрөө)-д нөхөгдсөн үндсэн болон үргэлжлэл хуудаснуудын тооллогын комиссын дугаар, тоологчийн дугаар, тооллогын хуудасны дугаар нь ижлээр нөхөгдөнө. **Харин тухайн өрх (нийтийн байрны нэг өрөө)-ийн хувьд тооллогын хуудасны тоо нь үндсэн болон үргэлжлэл хуудасны тоотой тэнцүү байна.** Тооллогын хуудасны тоо нь зөвхөн тооллогын үндсэн хуудасны нүүрэн хэсэгт тавигдсан байх ёстой.

## г. Тооллогын хуудасны хүнтэй холбогдох асуултыг нөхөх заавар

**Эцгийн (эхийн) нэр:** Улсын Их Хурлаар 1999 онд батлагдсан “Гэр бүлийн тухай” Монгол Улсын хуулийн 24 дүгээр зүйлийн гуравт “Хүүхэд эцгийн нэрийг авна”, мөн зүйлийн дөрөвт “Гэрлэлтээ бүртгүүлээгүй эхээс төрсөн, эсвэл хүүхдийн эцгийг тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэргүй бол хүүхэд эхийн нэрийг авна” гэсэн заалтуудыг үндэслэн тооллогын хуудасны эхэнд тоолуулагчийн эцгийн (эхийн), өөрийнх нь нэрийг товчлохгүйгээр бүрэн гүйцэд бичнэ. Эцгийн (эхийн) нэрийн төгсгөлд “ийн”,”ын” дагавар залгахгүй. Жишээ нь эцгийн нэр нь Дорж, өөрийн нэр нь Бат гэдэг хүнийг Доржийн Бат гэж бичихгүй. Эцгийн нэр, өөрийн нэр гэсний харалдаа “Дорж”, “ Бат” гэж бичнэ. Эцгийн нэрийг бичих зураасны өмнөх тоо нь тухайн өрх (нийтийн байрны өрөө тасалгаа)-д тоологдсон хүний дэс дугаар болно. **Энэ дугаар нь тооллогын материалыг компьютераар боловсруулахад ашиглагдах учир засварлах, алгасах, ялангуяа үргэлжлэл хуудсанд дэс дугаар алдаж дугаарлаж хэрхэвч болохгүйг тоологч анхаарах хэрэгтэй.**

**Өрхийн тэргүүлэгч.** Ам бүлийн гишүүд хэнийгээ өрхийн тэргүүлэгч гэхийг тэдний сайн дурын үндсэн дээр шийдвэрлэнэ. Гэхдээ хүн ам, орон сууцны тооллогын хуудасны асуултад хариулахад өрхийн тэргүүлэгч нь өрхдөө байнга оршин суугч хүн байх шаардлагатай. Хэрэв ам бүлийн гишүүд хэнийгээ өрхийн тэргүүлэгч болгохоо шийдэж чадахгүй байгаа тохиолдолд 16-аас дээш настай, ажил хөдөлмөр эрхэлдэг буюу өрхийн орлогод голлох хувь нэмэр оруулдаг ам бүлийн аль нэг гишүүнийг өрхийн тэргүүлэгч гэж холбогдох асуултыг нөхөж болно. Тэгэхдээ 18 нас хүрсэн гишүүдийн өрхийн саналыг харгалзах хэрэгтэй.

НЭГДҮГЭЭР АСУУЛТ

**Өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох.**

а. Өрхийн ам бүлийн гишүүд өрхийн тэргүүлэгчтэйгээ ямар хамааралтай болохыг асууж код 01-10-ын аль тохирох ганцхан кодыг хүн тус бүрт дугуйлна.

б. **Хамааралгүй**

•Өрхийн тэргүүлэгчтэй ураг төрлийн ямар нэг хамааралгүй, тооллогод тусдаа өрх үүсгэхгүй хүмүүсийг энд хамруулна.

• Тооллогын хуудасны нүүрэн талд нийтийн болон бусад байр-3 гэж нөхөгдсөн, гэр бүлийн болон ураг төрлийн холбоогүй бүх хүний хувьд энэ асуултад "хамааралгүй" гэж бичигдэнэ.

ХОЁРДУГААР АСУУЛТ

**Хүйс**. Тооллогын хуудсанд энэ асуултын хариултыг нөхөхдөө Эрэгтэй -1, Эмэгтэй-2 гэсний аль тохирох кодыг дугуйлна. Энэ асуултанд бүх хүн заавал хариулсан байх учиртайг тоологч анхаарах хэрэгтэй.

ГУРАВДУГААР АСУУЛТ

**Төрсөн он, сар.** Хүний төрсөн он, сарыг уг хүний хэлснээр бичнэ. Тэгэхдээ паспорт, төрсний гэрчилгээ, оршин суух үнэмлэх бусад баримт бичигт байгаатайгаа зөрүүлэхгүй байхыг **Тоологч** уг иргэнд сануулах хэрэгтэй. Тоолуулж байгаа хүн төрсөн он, сараа сайн мэдэхгүй эргэлзэх тохиолдолд өөрийнх нь зөвшөөрснөөр тухайн хүний паспорт, төрсний гэрчилгээ, түүнтэй адилтгах баримт бичгийг үзэж болно. Төрсөн он, сараа аргын тооллоор хариулахдаа эргэлзэж, харин төрсөн оноо билгийн тооллоор мэдэж байгаа хүмүүстэй сайтар ярилцан, насаар нь хөөж, эсвэл Хавсралт-5а, 5.б-г ашиглан билгийн тооллоор төрсөн жилийг нь зөв тогтоох хэрэгтэй.

ДӨРӨВДҮГЭЭР АСУУЛТ

**Нас (Бүтэн жилээр).** Хүний насыг бүтэн насаар нь авна. Бүтэн наслахад хэдхэн хоног дутуу байлаа ч насыг дэвшүүлж болохгүй. Нэг нас хүрээгүй хүүхдийн насыг "000" гэж бичнэ. Хүний насыг төрсөн он, сар, өдрөөр нь тооцож тогтооно. Тоологч эхлээд хүний төрсөн он, сар, өдөр, насыг асууж тооллого явуулж байгаа 2000 оны 1-р сарын 5-ны өдөртэй харьцуулан тооцож, тохирохгүй байвал тоолуулагчаас дахин лавлаж зөв насыг тогтооно. Гэхдээ төрсөн оноо мэдэж байгаа тохиолдолд Хавсралт –5.а-аас харж нөхөж болно. Харин аргын тооллоор насаа сайн мэдэхгүй, билгийн тооллоор

төрсөн жилээ мэдэж байвал Хавсралт-5.б-ыг ашиглан насыг тогтооно.

ТАВ ДУГААР АСУУЛТ

**Аль улсын харъяат.** Энэ асуултын хариултыг иргэдийн өөрсдийнх нь хариулснаар нөхөнө. Тэгэхдээ улсын нэрийг хамгийн ойлгомжтой товч нэрээр нь бичнэ. Монгол Улсын харъяат бүх иргэдийн хувьд Монгол Улс гэсний арын 01 гэсэн кодыг дугуйлна. Харин гадаадын харъяат иргэдийн хувьд улсын нэрийг нь Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ) гэж бичихгүй **Хятад** гэж Хавсралт-4-ийн "Тооллогын хуудсанд бичих нэр" гэсэн баганад бичигдсэнээр нь бичнэ. Тодруулбал, уул гадаадын харъяат хүн аль улсын иргэн болохыг тодорхой илэрхийлсэн байх ёстой. БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны иргэн байхад түүнийг "ӨМӨЗО" гэж бичихгүй "Хятад" гэж бичнэ.

Эцэг, эх нь хоёр өөр улсын харъяат бол 16-аас дээш настай хүн эцэг, эхийнхээ харъяатын алиныг дагахаа өөрсдөө шийдвэрлэнэ. Харин 16-аас доош настай бол эцэг, эхийнх нь саналыг үндэслэнэ. Хэрэв эцэг, эхийнх нь санал зөрвөл эхийнх нь харъяаллыг дагуулна.

Аль ч улсын харъяалалгүй хүмүүсийг "Харъяалалгүй" гэсний арын 88 гэсэн кодыг дугуйлна.

ЗУРГААДУГААР АСУУЛТ

**Яс үндэс.** Энэ асуултад Монгол Улсын харъяат иргэд хариулна. Гадаадын харъяат иргэд, харъяалалгүй хүмүүс хариулахгүй. Монгол улсын харъяат иргэн ямар ястан үндэстэн болохыг өөрийнх нь хариулснаар нөхнө. Хүүхдийн яс үндсийг эх, эцэг нь тодорхойлно. Хэрэв эцэг, эх нь тодорхойлж чадахгүй тохиолдолд хүүхдийн яс үндсийг эхийнхтэй ижлээр нөхнө. Тэгэхдээ Монгол улсын харъяат иргэдээс "Халх" ястан бол Халх гэсний арын 01 гэсэн кодыг дугуйлна. Халхаас бусад ястны нэрийг бичиж, кодыг нь энэ зааврын Хавсралт-3-аас харж тоологч нөхнө. Энд "Халх" ястанг ганцааранг нь зориуд ялган харуулж, бусад ястны нэрийг бичихээр тооллогын хуудсанд тусгасныг тоологч хүмүүст зөв ойлгуулах хэрэгтэй. Энэ нь бусад ястан үндэстнийг үл тоомсорлосон хэрэг огт биш юм. Гагцхүү тооллогын хуудсыг бөглөхөд тоологчийн ажлыг хөнгөвчлөхийн үүднээс ингэж оруулсан болно. Учир нь монгол улсын хүн амын 80 шахам хувь нь "Халх" ястан байдаг учир

тоологчид “Халх” гэдэг үгийг олон дахин бичихээс зайлсхийж бэлэн хэвлэгдсэн кодыг дугуйлахаар оруулсан болно.

ДОЛООДУГААР АСУУЛТ

**Суурьшил.** Тоолуулж байгаа хүнийг тооллогын хугацааны тов буюу 2000 оны 1-р сарын 4-нөөс 5-нд шилжих шөнийн 24 цагийн байдлаар тухайн засаг захиргааны нэгжид 6 сараас дээш, доош хугацаагаар байгаа эсэхийг харгалзан байнга, түр эзгүй, түр сууж байгаа байдлаар нь аль тохирох кодыг дугуйлна. Засаг захиргааны нэгж гэдгийг **аймагт сум, нийслэлд дүүрэг** гэж үзнэ. Харин тухайн сум, дүүрэгт түр эзгүйгээр тоологдсон хүн тооллогын үед байгаа газартаа түр суугаагаар тоологдоно.

Хүний суурьшлыг тодорхойлохдоо тооллогын өмнөх өрх, хүн амын бүртгэлтэйгээ тоологч тулган шалгаж тухайн хүний суурьшлыг зөв нөхөхөд анхаарах хэрэгтэй.

**а. “Байнга”** хүн амд:

1.Тооллогын хугацааны товын байдлаар тухайн засаг захиргааныхаа нэгждээ 6 сараас дээш хугацаагаар оршин сууж байгаа хүмүүс

2. Тооллогын хугацааны товын байдлаар тухайн засаг захиргааны нэгждээ 6 сараас доош хугацаагаар сууж байгаа ч цаашид 6 сараас дээш хугацаагаар оршин суух хүмүүс

3.Тооллогын өмнөх өрх, хүн амын бүртгэлд байнга суугаагаар бүртгэгдсэн боловч тооллогын үед өрхдөө байхгүй байгаа, өөр газарт тоологдохгүйгээр гэртээ буцаж ирэх дараах хүмүүсийг нэг адил байнга суугаагаар тоолно. Үүнд:

- ээлжийн ажилтай хүмүүс,
- харуул, манаа, жижүүр хийгчид,
- албан ажлаа хэд хэдэн хоногоор үргэлжлүүлэн гүйцэтгэдэг (төмөр замчид, агаарын болон авто тээврийн ажиллагчид, шуудан хүргэгчид гэх мэт) хүмүүс,
- амралт сувилал, аялал жуулчлалд явсан тооллогын хугацаанд гэртээ эргэж ирэх хүмүүс, 24 цагийн ажиллагаатай ясли, цэцэрлэгт явдаг хүүхдүүд,
- замд буюу хээр яваа (түлээ түүх, мал хариулах, алдсан малаа хайж яваа, ан гөрөө хийж яваа гэх мэт) хүмүүс,
- цэргийн цугларалт, хээрийн сургуульд яваа хүмүүс,
- төрөх газарт байгаа хүүхэд, эхчүүд,
- засаг захиргааныхаа үндсэн нэгж буюу тухайн сум, дүүргийнхээ нутаг дэвсгэрт айлд байгаа хүмүүс

4. Тооллогын хугацааны товын өмнө засаг захиргааныхаа үндсэн нэгжид байсан, товоос хойш өөр газарт явсан хүнийг байнга суугчаар тоолно. Жишээ нь тоологч 1-р сарын 9-нд тооллогын ажлаар өрхөд ороход мөн сарын 6-нд өрхийн нэг гишүүн өөр аймаг руу 14 хоногийн хугацаагаар явсан байвал уг хүнийг гэрт нь байнгаар тоолно. **Харин нөгөө очсон засаг захиргааны нэгжид нь тэр хүнийг тоолохгүй.**

5.Байнга оршин суудаг газар нь тодорхойгүй хүмүүсийг (тэнэмэл хүмүүс зэрэг) тооллогын үед байгаа газарт нь байнга суугчаар тоолно.

**б. Түр эзгүй**

1.Тооллогын хугацааны товын үед үндсэн засаг захиргааныхаа нэгжээс гадагш 6 сараас илүүгүй хугацаагаар явсан хүмүүсийг "Түр эзгүй" гэж үзнэ. Эдгээр хүмүүс нь тооллогын үед сууж байгаа газартаа "түр суугаа" гэж тоологдох ёстой.

2.Тооллогын өмнөх өрх, хүн амын бүртгэлд байгаа эсэхийг харгалзахгүй тооллогын үед гадаадад байгаа (гадаадад байгаа Монгол улсын дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагад ажиллаж байгаа хүмүүс, тэдний гэр бүлийнхнээс бусад) хүмүүсийг **хугацаа харгалзахгүйгээр** "түр эзгүй" гэж тоолно.

Үүнд:

- гадаадад ажиллаж байгаа
- гадаадад суралцаж байгаа
- гадаадад албан болон хувийн журмаар яваа

**в. Түр суугаа**

1. Тооллогын хугацааны товоос өмнө өөр засаг захиргааны нэгжээс ирж 6 сараас доош хугацаагаар сууж байгаа хүмүүсийг "Түр суугаа" гэж тоолно. Байнга оршин суудаг засаг захиргааныхаа нэгждээ (нутаг дэвсгэртээ) "Түр эзгүй" гэж тоологдох хүмүүс тооллогын үед байгаа газартаа "Түр суугаа" гэж тоологдоно.

2.Хүн амыг тооллогод хамрагдсан байдлыг нисэх онгоц, галт тэрэг, авто тээврийн буудал болон шалгалт хийгдэж байгаа бусад цэгүүдэд шалгах явцад уг хүн тооллогод хамрагдаагүй нь нотлогдвол, ("гэрчилгээгүй" бол) түүнийг "Түр суугаа" гэж тоолно. Жишээлбэл Л.Бат гэдэг хүн Сүхбаатар

аймагт байнга оршин суудаг бөгөөд харин тооллогын хугацааны тов буюу 2000 оны 1-р сарын 4-нөөс 5-нд шилжих шөнийн 24 цагаас өмнө томилолтоор Улаанбаатар хотод ирж зочид буудалд байрлаж байгаа нөхцөлд тоологч уг хүнийг тооллогод хамрагдсан гэрчилгээтэй эсэхийг шалгаж, гэрчилгээгүй бол уг хүнийг тоолж, тооллогын хуудасны 7-р асуултад "түр суугаа" гэж нөхнө

**Түр эзгүй хүний түр сууж байгаа, түр сууж байгаа хүний байнга суудаг аймаг, нийслэл /улс/, сум, дүүрэг /хот/-ийн нэр.**

Тооллогын хуудасны 7-р асуултад "түр суугаа" гэж хариулсан хүний байнга оршин суудаг аймаг, нийслэл, сум, дүүргийн (гадаадаас ирсэн бол улс, хотын) нэрийг, "түр эзгүй" хүний түр суугаа аймаг, нийслэл, сум, дүүргийн (гадаадад байгаа хүний түр сууж байгаа улс, хотын) нэрийг бичиж, кодыг энэ зааврын Хавсралт-1 болон 4-өөс харж нөхнө.

НАЙМДУГААР АСУУЛТ

**Та байнга суудаг аймагтаа (нийслэлдээ) хэдийнээс сууж байна вэ?**

Тоолуулагч тооллого явагдах үед байнга сууж байгаа аймагтаа төрснөөсөө хойш сууж байгаа бол "Төрснөөс хойш" гэдэгт хамаарах "1" гэсэн кодыг дугуйлна.

Хэрэв шилжиж ирсэн бол "Шилжиж ирсэн" гэдэгт хамаарах "2" гэсэн кодыг дугуйлна. Гэхдээ тоолуулагч тооллогын үед сууж байгаа аймаг, нийслэлдээ төрсөн боловч өмнө нь 6 сараас дээш хугацаагаар өөр газар сууж байгаад эргэж ирсэн бол "Төрснөөс хойш" сууж байгаа гэж үзэхгүй, "Шилжиж ирсэн" гэж үзэж код "2"-ыг дугуйлна. "Түр суугаа" хүмүүс байнга суудаг аймагтаа төрснөөсөө хойш сууж байгаа эсэхээ хариулна. Жишээ нь Увс аймгийн Сагил сумаас Улаанбаатар хотод Лувсан гэдэг хүн тооллогын хугацааны товоос өмнө түр хугацаагаар ирээд тоолуулж байгаа нөхцөлд тоологч тооллогын хуудасны 7-р асуултад уул хүний суурьшлыг "түр суугаа" гэж нөхөж, дараа нь 8-р асуултыг асуухдаа "Та Увс аймгийн Сагил суманд байнга оршин суудаг" гэж 7-р асуултад хариулсан. Та тэндээ (Увс аймагтаа) төрснөөсөө хойш амьдарч байна уу эсвэл өөр аймаг, нийслэлээс шилжиж очсон уу гэдгийг асууж байгааг тоологч, тоолуулагчдад ойлгуулах хэрэгтэй.

Тооллогын үед энэ асуултад гадаадад сууж байгаа хүнийхээ тухай өрхийн ам бүлийн гишүүд хариулахдаа гадаадад сууж байгаа хугацааг харгалзахгүйгээр түүний гадаадад суухаас өмнөх байнга оршин сууж байсан аймагтаа төрснөөсөө хойш сууж байсан эсэхээр нь хариулна. Харин гадаадад төрсөн Монгол улсын харъяат болон тооллогын үед манай улсад удаан хугацаагаар сууж байгаа гадаадын харъяат, цагаач иргэд, харъяалалгүй хүмүүсийн хувьд шилжиж ирсэн гэж үзнэ.

Төрснөөс хойш энэ аймагтаа сууж байгаа гэж хариулсан хүнээс тооллогын хуудасны 9,10-р асуултыг асуухгүй шууд 11-р асуултад шилжинэ.

"Шилжиж ирсэн" гэж хариулсан хүнээс шилжиж ирсэн аймаг, нийслэл(улс)-ийн нэр болон оныг асууж нөхсөний дараа тооллогын хуудасны 9,10-р асуултыг асууна.

Тооллого явагдаж байгаа аймаг, нийслэлд "шилжиж ирсэн" гэж хариулсан хүн, тооллогын үед байнга оршин сууж байгаа аймаг, нийслэлд шилжиж ирэх хүртлээ хэдэн газарт хичнээн удаа шилжсэнийг харгалзахгүйгээр, одоо оршин суугаа аймаг, нийслэлд ирэхийн өмнө хаана байсныг асууж нэрийг аймаг, нийслэл /улс/ гэсний арын зайд бичиж, кодыг Хавсралт-1-ээс харж нөхнө. Гадаадаас ирсэн Монгол Улсын харъяат иргэдийн сууж байсан, гадаадын харъяат иргэдийн өөрийнх нь улсын нэр, кодыг Хавсралт-4-өөс харж нөхнө.

Шилжиж ирсэн он гэсэн асуултанд тооллогын үед байнга оршин сууж байгаа газартаа шилжиж ирсэн оныг бичнэ.

ЕСДҮГЭЭР АСУУЛТ

**Төрсөн аймаг, нийслэл (улс)-ийн нэр.**

Хүний төрсөн аймаг, нийслэлийг одоогийн нэрээр, товчлолгүй бичиж, кодыг Хавсралт-1-ээс харж бичнэ. Уул хүн гадаадад төрсөн бол улсынх нь нэрийг аймаг, нийслэл гэсэн зайд бичиж, кодыг нь Хавсралт-4-өөс харж бичнэ. "Та байнга суудаг аймагтаа /нийслэлдээ/ хэдийнээс сууж байна вэ?" гэсэн 8-р асуултанд "**төрснөөс хойш**" гэж хариулсан хүн энэ асуултад хариулахгүй.

АРАВДУГААР АСУУЛТ

**1995 оны 01 - 01-нд байнга сууж байсан аймаг, нийслэл (улс).** Энэ асуултад 1995 оны 01-р сарын 01-ээс өмнө төрсөн буюу тооллогын үед 5 ба түүнээс дээш настай (бүтэн насалсан нас) хүн бүр хариулна. Тооллого явагдахаас 5 жилийн өмнө буюу 1995 оны 01-р сарын 01-нд тоолуулагчийн байнга оршин сууж байсан аймаг, нийслэл(улс)-ийн нэрийг бичиж, кодыг Хавсралт-1,4-өөс харж бичнэ. Энэ асуулт нь тооллого эхлэхээс 5 жилийн өмнө тухайн хүний хаана байнга оршин сууж байсныг харуулах зорилготой бөгөөд харин зөвхөн 1995 оны 01-р сарын 01-нд хаана байсныг онцолж байгаа бус юм. Тоолуулагч 5 жилийн өмнө хаана оршин сууж байснаа сайн санахгүй байвал 1995 оны эхэнд хаана байнга оршин сууж байсныг нь тодруулах зэргээр зөв хариулт авахыг хичээх хэрэгтэй. "Та байнга суудаг аймагтаа /нийслэлдээ/ хэдийнээс сууж байна вэ?" гэсэн 8-р асуултад төрснөөс хойш гэж хариулсан хүн энэ асуултад хариулахгүй

АРВАН НЭГДҮГЭЭР АСУУЛТ

**Боловсрол.** Энэ асуултад 7 ба түүнээс дээш настай бүх хүн хариулна. Энэ асуулт нь тоолуулагчийн боловсролтой эсэх, боловсролтой бол ямар түвшний боловсролтойг асууж байгаа болно. Тоологч эхлээд "Та ямар нэг боловсролтой юу?" гэж асуугаад хэрэв тоолуулагч "боловсролгүй" гэж хариулбал "1" гэсэн кодыг дугуйлж, 12-р асуулт руу шилжинэ. Бага боловсрол эзэмшээгүй, өөрөөр хэлбэл ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр анги(1975 он хүртэл, 1997 оноос хойш), 3 дугаар ангийг (1975-1996 он) төгсөөгүй хүнийг боловсролгүй гэнэ. Жишээ нь ерөнхий боловсролын сургуулийн 1-4-р ангид одоо сурч байгаа хүүхэд эсхүл сурч байгаад сургуулиа орхин (ерөнхий боловсролын 3;4-р ангийг төгсгөлгүй) боловсрол эзэмшээгүй хүмүүс хамаарна.

Тоолуулагч "боловсролтой" гэж хариулбал түүний боловсролын дээд түвшнийг лавлан асуугаад тохирох кодыг дугуйлж, 13-р асуулт руу шилжинэ. Боловсролын **дээд түвшин** гэдэгт тухайн хүний эзэмшсэн боловсролын хамгийн дээд түвшнийг нь хэлнэ. Жишээ нь Цэрэндулам гэдэг хүн Санхүү эдийн засгийн техникумд (хуучин нэрээр) суралцаж, тусгай мэргэжлийн дунд боловсролтой, нягтлан бодогчийн мэргэжил эзэмшсэн болович дараа нь их, дээд сургуульд ямар нэг мэргэжлээр суралцаж, баклавр эсхүл магистрын зэрэгтэй

дипломтой төгссөн бол Цэрэндуламыг дээд боловсролтой гэж үзэж 7 гэсэн кодыг дугуйлна.

Тоолуулагч ерөнхий боловсролын сургуулийн 10-р ангийг төгсөөд цаашид суралцаагүй бол уул хүнийг бүрэн дунд боловсролтой гэж үзэж 4 гэсэн кодыг дугуйлна.

Боловсролын түвшинг дараах байдлаар тодорхойлно.

**а. Бага боловсрол**

•Ерөнхий боловсролын сургуулийн 4-р анги (1975 оныг хүртэл хуучин системээр),

•1975-1996 оныг дуустал 3-р анги,

•1997 оноос хойш 4-р анги төгссөн хүмүүсийг бага боловсролтой гэж үзнэ.

**б. Бүрэн бус дунд боловсрол**

Ерөнхий боловсролын 7-р анги (1975 он хүртэл хуучин системээр), 8-р анги төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг бүрэн бус дунд боловсролтой гэж үзнэ.

**в. Бүрэн дунд боловсрол**

Ерөнхий боловсролын сургуулийн 10(11) -р ангийг өдөр, оройгоор төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг бүрэн дунд боловсролтой гэж үзнэ..

**г.Техник мэргэжлийн боловсрол**

Техник мэргэжлийн сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв төгссөн, үнэмлэхтэй хүмүүсийг техник мэргэжлийн боловсролтой гэж үзнэ.

**д. Тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд боловсрол**

Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль, түүнтэй адилтгах сургууль төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг тусгай мэргэжлийн дунд боловсролтой гэж үзнэ.

Бүрэн бус дээд боловсролтой хүмүүст:

•Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр төгссөн,

•Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө төгссөн,

•Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс,

•Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль,

•Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгсөгчид,

•Их, дээд сургууль, коллежид 1994 оноос хойш 3-аас доошгүй жил суралцаж, дипломын зэрэгтэй боловсрол эзэмшигчдийг хамруулна. Жишээ нь Санхүү, эдийн засгийн дээд сургуульд 3 жил суралцаж, дипломын зэрэгтэй боловсрол эзэмшсэн болович кредит баллын үнэлгээгээр буюу эсвэл тодорхой сэдвээр дипломын ажил бичиж хамгаалан баклавр, магистрын зэрэгтэй боловсролын диплом аваагүй хүмүүсийг бүрэн бус дээд боловсролтой гэж үзнэ.

**а.Дээд боловсрол**

Гадаад, дотоодын их, дээд сургууль төгссөн хүнийг (баклавр, магистрын зэрэгтэй диплом, түүнтэй адилтгах үнэмлэхтэй бол) дээд боловсролтой гэж үзнэ. Түүнчлэн коллеж, түүнтэй адилтгах сургуулийг баклаавр түүнээс дээш зэрэгтэй төгсөгчдийг мөн үүнд хамруулна.

АРВАН ХОЁРДУГААР АСУУЛТ

**Бичиг үсгийн мэдлэг.** Энэ асуултад өмнөх 11-р асуултад "боловсролгүй" гэж хариулсан хүн хариулна. Ямар нэг түвшний боловсрол эзэмшээгүй, аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаг хүнийг бичиг үсэг мэддэг гэж үзнэ. Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаггүй хүнийг бичиг үсэг мэддэггүй гэж үзнэ.

АРВАН ГУРАВДУГААР АСУУЛТ

**Та одоо сургуульд сурдаг уу?.** Энэ асуултад 7- 29 насны хүмүүс хариулна. Тоолуулагч боловсрол олгох ямар нэг шатны сургуульд өдрийн болон орой, эчнээ ангиар суралцаж байгаа бол **тийм** "1" гэсэн кодыг , суралцдаггүй бол **үгүй** "2" гэсэн кодыг дугуйлна. Ямар нэг шатны боловсрол олгодоггүй **албан бус боловсролын** сургалтад хамрагдагчдыг сургуульд сурдаг гэж үзэхгүй. Албан бус боловсролын сургалт гэж сургуулиас гадуурх зохион байгуулалттай сургалтын үйл ажиллагааг хэлнэ. Үүнд төрөл бүрийн мэргэжил олгох(жолооны, гадаад хэлний, тогоочийн, компьютерийн гэх мэт) эсхүл амьдрах ухаанд сургах (ногоо тарих, алт мөнгөний дархан зэрэг) сургалтыг хамруулна. Холын зайн сургалт нь албан бус боловсролын сургалтад хамаарна.

## АРВАН ДӨРӨВДҮГЭЭР АСУУЛТ

### Гэрлэлтийн байдал

Энэ асуултад 15 -аас дээш настай хүн хариулна. "Гэр бүлийн тухай" Монгол улсын хуулиар 18 нас хүрсэн хүн гэрлэх боловч амьдралд 18-аас доош насны хүүхэд, залуус гэрлэсэн тохиолдол цөөнгүй байдаг. Мөн хүн амын тооллогын талаарх олон улсын аргачлал нь 15 наснаас эхлэн гэрлэлтийн байдлыг асуудаг. Тоологч 18 нас хүрээгүй хүмүүсээс ялангуяа 15-16 настай хүүхдүүдээс энэ асуултыг маш болгоомжтой, тэднийг ичээж, эвгүй байдалд оруулахгүйгээр "энэ хүүхэд чинь гэрлээгүй биз дээ?" гэсэн байдлаар эвтэйхэн асуух хэрэгтэй. 18 нас хүрээгүй хүүхэд, залуус гэр бүлтэй бол тэдгээрийг **"батлуулаагүй гэр бүлтэй"** гэж нөхнө.

**а.Огт гэр бүл болоогүй.** Арван тав түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүнийг энд хамруулна.

**б. Батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй.** Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүмүүсийг **"Батлуулсан гэр бүлтэй"** гэж үзнэ. Хэдийгээр гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгалзахгүйгээр) иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ батлуулаагүй хүмүүсийг **"Батлуулаагүй гэр бүлтэй"** гэж үзнэ.

**в.Тусгаарласан.** Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй, тусдаа амьдарч байгаа хүмүүсийг **"Тусгаарласан"** гэж үзнэ.

**г.Цуцалсан.** Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойшхи хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлээгүй хүмүүсийг **"Цуцалсан"** гэж үзнэ.

**д.Бэлбэсэн.** Эхнэр, нөхрийн аль нэг нь нас барснаас хойш ямар хугацаа өнгөрснийг харгалзахгүйгээр дахин гэрлээгүй бол **"Бэлбэсэн"** гэж үзнэ.

АРВАН ТАВДУГААР АСУУЛТ

**Та сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн үү?**

Энэ асуултыг 15 ба түүнээс дээш настай бүх хүнээс тооллогоос өмнөх 7 хоногт, өөрөөр хэлбэл 1999 оны 12-р сарын сүүлч, 2000 он гарангуут ядаж нэг өдөр цалин, орлоготой ажил эрхэлсэн үү? гэж асууна.

**А. Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн буюу "Тийм" гэсэн хариултын 1 гэсэн кодыг дараах нөхцөлд дугуйлна. Үүнд:**

1. Тооллогын өмнөх 7 хоногийн турш эсхүл аль нэг өдөр цалин, орлоготой ажил эрхэлсэн бүх хүмүүс,

*Ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын төрөл, өмчийн хэлбэр, тухайн хүний эрхэлж байгаа ажлын зэрэг дэв зэргийг харгалзахгүй ажил эрхэлж байгаа бүх хүмүүс, мөн зах, гудамж, талбайд наймаа худалдаа хийгчид, гутал тослогч, сонин борлуулагч, машин угаагч, гар урлал хийгчид, түүхий эд цуглуулагчид зэрэг хүмүүс бүгд энд хамрагдана.*

2. Тооллогын өмнөх 7 хоногт ажиллаагүй боловч үндсэн байгууллагатайгаа хөдөлмөрийн гэрээ хэлцлээ цуцлаагүй ямар нэг тодорхой хугацааны дараа ажилдаа эргэн орох дараах хүмүүс, Үүнд:

а.Жирэмсний, хүүхэд төрүүлсний, 2 хүртэлх настай хүүхдээ асрахаар ажлаас чөлөө авсан хүмүүс,

б.Өвчний болон гэмтсэний улмаас урт, богино хугацааны түр чөлөө авсан хүмүүс,

в.Захиргааны түр чөлөөтэй хүмүүс (цалинтай, цалингүй харгалзахгүй),

г.Газар тариалан, алт олборлох, барилга, геологи хайгуул гэх зэрэг улирлын чанартай ажил үйлдвэрлэл эрхэлдэг учраас өвлийн улиралд түр ажиллахгүй байгаа хүмүүс,

д.Аж ахуйн нэгж, байгууллага нь ямар нэг шалтгаанаар (ажилчид нь ажил хаясан, үйлдвэрийн осол гарсан гэх мэт) ажлаа зогсоосон, сургалтад хамрагдсан болон бусад шалтгааны улмаас түр хугацаагаар ажил хийгээгүй хүмүүс,

3. Өрхийн үйлдвэрлэл (мал аж ахуй, газар тариалан болон бусад төрлийн бизнес) эрхэлдэг өрхийн ам бүлийн гишүүдийн ажил эрхлэлтийн байдлыг дараах байдлаар тодорхойлно.

*Өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг өрх гэдэг нь зах зээлд борлуулах болон өөрсдийн хэрэгцээнд зориулан тодорхой бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг, үйлчилгээ эрхэлдэг өрхийг хэлнэ. Манай орны хувьд малчин айл бүр өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг өрх болно. Түүнчлэн газар тариалан эрхэлдэг, гэр бүлээрээ хамтран, эсвэл түүний аль нэг гишүүн нь үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж орлогоо хамтран эзэмшдэг бол үүнд мөн хамаарна.*

а. Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд оролцдог, 15-аас дээш насны, өөр ажил эрхэлж цалин, орлого олдоггүй хүмүүсийг ажил эрхэлдэг гэж үзнэ.

б. Өндөр насны тэтгэвэр, нөхөн олговор авдаг болон тахир дутуугийн группт байгаа боловч өрхийнхөө үйлдвэрлэл, үйлчилгээнд оролцож, түүнээс олсон орлого нь амьдралынх нь гол эх үүсвэр болдог хүмүүсийг ажил эрхэлдэг гэж үзнэ.

4. Өндөр насны тэтгэвэр, нөхөн олговор авдаг болон тахир дутуугийн группд байгаа хүмүүс цалин орлоготой ажил эрхэлж байгаа бол ажил эрхэлж байгаа гэж үзнэ.

5. Бүх шатны сургууль, дамжаанд өдрөөр суралцагчид хичээлийнхээ зав чөлөөгөөр тооллогын өмнөх 7 хоногийн аль нэг өдөр цалин орлоготой ажил эрхэлсэн бол ажил эрхэлдэг гэж үзнэ.

Дээрх асуултад **"Тийм"-** гэж хариулсан хүмүүсээс 16, 17, 18 дугаар асуултуудыг үргэлжлүүлэн асууна.

**Б. Тухайн хүн сүүлийн 7 хоногт ажил эрхлээгүй гэж хариулбал "Үгүй" гэж 2 гэсэн кодыг дугуйлж арван есдүгээр асуулт ( Та яагаад ажил эрхлэхгүй байна вэ? ) руу шууд шилжинэ.**

**"Үгүй"** гэж 2 гэсэн кодыг дугуйлахын өмнө ажил эрхлээгүй гэж хариулсан хүмүүстэй тоологч сайтар лавлан ярилцаж тодруулах хэрэгтэй.

## АРВАН ЗУРГААДУГААР АСУУЛТ

### Эрхэлдэг ажил

Тооллогын хуудасны 15-р асуултад "Тийм-1" гэж хариулсан хүмүүсээс энэ асуултыг асууна. Асуултыг *Та ямар ажил төрөл эрхэлдэг вэ? Та ямар албан тушаал дээр ажилладаг вэ ?* гэсэн байдлаар асууна. Эрхэлдэг ажлыг үнэн зөв тодорхойлоход дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

1. Тоологч тухайн хүний эзэмшсэн мэргэжил биш харин түүний эрхэлж байгаа ажил, албан тушаал, гүйцэтгэдэг үүргийг асууж байгаа гэдгээ түүнд ойлгуулах хэрэгтэй. Эзэмшсэн мэргэжил, хийж гүйцэтгэж байгаа ажил заавал давхцах албагүй. Жишээлбэл, "нягтлан бодогч"-ийн мэргэжилтэй хүн "боловсон хүчний тасгийн дарга"-ын ажил эрхэлж байж болно.

2. Хэрэв тоолуулагч өөрийн эрхэлдэг ажлаа тодорхой бус Жишээлбэл, багш, операторч, менежер, жолооч гэх мэт ерөнхий байдлаар хариулбал, *Та ямар сургуульд юуны багш хийдэг вэ?. Та юуны операторч вэ? Та юу хариуцсан менежер вэ? Та ямар машины жолооч вэ?* гэх мэтээр маш сайн тодруулж асуугаад "дээд сургуулийн математикийн багш", "химийн цэвэрлэгээний машины операторч", "борлуулалт хариуцсан менежер", "ачааны машины жолооч" гэх мэтээр хариултыг дэлгэрэнгүй авч бүрэн бүтэн бичнэ. (Тооллогын хуудасны 15-19-р асуултыг нөхөх загварыг хар.)

3. Хэрэв тоолуулагч олон төрлийн ажил эрхэлдэг эсхүл хэд хэдэн албан тушаалыг хавсран гүйцэтгэдэг бол тухайн хүний ажлын цагийнхаа ихэнхийг зарцуулдаг ажил, албан тушаалыг бичнэ. Харин хоёр төрлийн ажил эрхэлдэг бөгөөд эдгээрт яг ижил цаг хугацаа зарцуулдаг бол аль их цалин орлого авдаг ажил, албан тушаалыг бичнэ.

4. Хэрэв тухайн хүн тооллогын өмнөх 7 хоногт ажил хийгээгүй боловч ажил эрхэлдэг байгууллагатайгаа хөдөлмөрийн гэрээ, хэлцлээ цуцлаагүй, тодорхой хугацааны дараа ажилдаа эргэж орох (15-р асуултын А хэсгийн 2-ийн "а"-аас "г"-д дурьдсан) бол тухайн байгууллагад эрхэлдэг ажлыг нь бичнэ.

АРВАН ДОЛДУГААР АСУУЛТ

**Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл**

Тооллогын хуудасны 15-р асуултад "Тийм-1" гэж хариулсан хүмүүсээс энэ асуултыг асууна.

Ажил эрхэлж буй хүний ажилладаг байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тухайн байгууллагын гаргаж байгаа үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг үндэслэн тодорхойлно.

Энэ асуултыг *Танай байгууллага ямар чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг вэ? Танай байгууллага ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг эсвэл ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?* гэсэн байдлаар асууж, тухайн хүний ажиллаж байгаа байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтооно. Тухайн хүний ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг үнэн зөв тодорхойлохын тулд дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

1. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг сайтар тодруулан асууж бичнэ. Жишээлбэл, тухайн хүний ажилладаг аж ахуйн нэгж, байгууллага *худалдааны байгууллага* бол ямар төрлийн бараа, бүтээгдэхүүний худалдаа эрхэлдэг, бөөний болон жижиглэнгийн худалдааны аль нь болох, *үйлчилгээний газар* бол ямар үйлчилгээ үзүүлдэг, үйлдвэрийн газар бол ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэх мэтээр тодруулна.

2. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлохдоо удирдлага, санхүүгийн хувьд биеэ даасан эсэхийг харгалзан үзнэ. Хэрэв аж ахуйн нэгж, байгууллага дотроо хэд хэдэн салбартай хирнээ нэгдсэн удирдлага, санхүү бүртгэлтэй бол салбар нэгжүүдийг голлох чиглэлийн үйл ажиллагаанд харъяалуулна. Жишээ нь:

а. "Улаанбаатар хивс" ХХК нь хивс үйлдвэрлэдэг үндсэн үйлдвэрлэлийн нэгжээс гадна ажиллагчиддаа зориулсан гуанзтай, эмнэлэгтэй, бүтээгдэхүүнээ борлуулдаг нэрийн барааны дэлгүүртэй гэж үзье.




Эдгээр нэгжүүд нь бие дааж тайлан бүртгэл хөтөлдөггүй, "Улаанбаатар хивс" ХХК-ныхаа удирдлага санхүүд харъяалагддаг гэж бодъё. Мөн өөрийн үйлдвэрийн байрны нэг хэсгийг нэгэн дэлгүүрт түрээсээр ашиглуулдаг байна.

Энэ тохиолдолд "Улаанбаатар хивс" ХХК-ийн эмнэлэгт ажилладаг эмч, гуанзанд ажилладаг тогооч, нэрийн барааны дэлгүүрийн худалдагч нарын "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл"-нь "Улаанбаатар хивс" ХХК-ний үйл ажиллагааны үндсэн чиглэл болох ***"Хивсний үйлдвэрлэл"*** болно. Харин "Улаанбаатар хивс" ХХК-ийн байранд түрээсээр ажилладаг төрөл бүрийн хүнсний барааны дэлгүүрийн худалдагчийн хувьд "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл"-нь ***"Хүнсний барааны дэлгүүрийн жижиглэн худалдаа"*** болно. Учир нь түрээсийн энэ дэлгүүрийн удирдлага, санхүү нь тусдаа бие даасан байдагт оршино.

б. "Эрэл" ХХК нь тоосгоны үйлдвэр, “Эрэл” банк, барилга угсралт, алтны уурхай гэсэн бие даасан тайлан бүртгэл хөтөлдөг тус тусдаа удирдлага, санхүүтэй дөрвөн охин компанитай гэж үзье. Мөн зарим охин компани, жишээлбэл, "Тоосго" охин компани дотроо эмнэлэг, нэрийн барааны дэлгүүр, гуанз гэсэн нэгжтэй байна.




Энэ тохиолдолд "Эрэл" компанийн "Тоосгоны үйлдвэр"-т ажиллаж байгаа хүний (уг үйлдвэрийн харъяа эмнэлгийн эмч, гуанзны тогооч, нэрийн барааны дэлгүүрийн худалдагч гэх мэт) үйл ажиллагааны үндсэн чиглэл нь ***“тоосго үйлдвэрлэл”***,

***"Эрэл"*** банкинд ажилладаг хүнийх (уг банкны мөнгө тоологч, нягтлан бодогч, гуанзны тогооч гэх мэт) ***"банкны үйл ажиллагаа"***, Барилга угсралтын компанид ажилладаг хүнийх (уг компанийн ажилчдын эмнэлгийн эмч, сувилагч, барилгачин гэх мэт) ***"барилга угсралтын ажил"***, Алтны уурхайд ажилладаг хүнийх (инженер, бульдозерчин, жижүүр гэх мэт) ***"алт олборлолт "*** болно.

Энд тоосгоны үйлдвэрийн гуанзны тогоочийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг ***"тоосго үйлдвэрлэл"***, Эрэл банкны гуанзны тогоочийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг ***"арилжааны банк"*** гэж тодорхойлж байгааг анхаар. Энд охин компанийн ажиллагчдын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг Эрэл ХХК-ныхаар биш охин компаниудынхаар авсан шалтгаан нь эдгээр компаниудын удирдлага, санхүү нь тусдаа биеэ даасан байдагт оршино.

в. Хэрэв тухайн аж ахуйн нэгж, байгууллага олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг бол хамгийн их ажиллагчтай нэгжийн үйл ажиллагааны чиглэлээр авна. "Отгон" компани баар, дэлгүүр, үсчин, биллъярдын үйлчилгээ эрхэлдэг. Эдгээр нь нэгдсэн удирдлага, санхүүтэй байна. Иймээс Отгон компанийн ажиллагчдын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хамгийн их ажиллагчидтай нэгжийн үйл ажиллагааны чиглэлээр авна. "Отгон" компанийн Баар тус компанийн хамгийн их ажиллагчидтай байвал тус компанийн ажиллагчдын (дэлгүүрийн худалдагч, үсчин) үйл ажиллагааны үндсэн чиглэл нь ***"Зоогийн газар, гуанз, цайны газрын үйлчилгээ"*** болно.




4. Хувиараа аж ахуй эрхлэгчдийн үйлдвэрлэл, үйлчилгээний үндсэн чиглэл. сайтар тодруулж нарийвчлан авах хэрэгтэй. Жишээлбэл,

- хүнсний жижиглэн худалдаа
- хүн тээврийн үйлчилгээ
- ачаа тээврийн үйлчилгээ
- сүлжмэл даавуу хувцас үйлдвэрлэгч
- талх, талхан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч
- мал аж ахуй

- газар тариалан гэх мэт

5. Бусдад хөлсөөр ажиллагчдын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг мөн тодорхой бичнэ. Жишээлбэл,

- гэрийн үйлчлэгч
- хүүхэд асрагч
- мал аж ахуйд
- газар тариаланд
- хүн тээврийн үйлчилгээ гэх мэт

6. Боловсролын байгууллагын ажиллагчдын хувьд үйл ажиллагааны үндсэн чиглэлийг доор өгөгдсөнөөс аль тохирохыг сонгож бичнэ.

- Анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа
- Дунд шатны боловсрол олгох үйл ажиллагаа
- Дээд боловсрол олгох үйл ажиллагаа
- Насанд хүрэгчдийн болон бусад боловсрол олгох үйл ажиллагаа

7.Бүх төрлийн хүн эмнэлэгийн үйл ажиллагааг ***хүн эмнэлгийн үйл ажиллагаа*** гэж авна.

**8.**Хууль тогтоох, гүйцэтгэх байгууллага, тэдгээрийн орон нутгийн удирдлага, санхүү, татвар, гааль, эдийн засаг, нийгмийн төлөвлөлт, эрдэм шинжилгээ, судалгаа эрхэлдэг яам, газар, байгууллагад ажиллагчдын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг *Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа* гэж авна.

**9.**Гадаад харилцаа, батлан хамгаалах, нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг хангах байгууллагад ажиллагчдыг үйл ажиллагааны үндсэн чиглэлийг *Улс нийгэм даяар үзүүлэх үйлчилгээ* гэж нөхнө.

АРВАН НАЙМДУГААР АСУУЛТ

**Ажил эрхлэлтийн байдал**

Тооллогын хуудасны 15-р асуултанд "Тийм-1" гэж хариулсан хүмүүсээс энэ асуултыг асууна.

Тоологч тоолуулж байгаа хүнтэй хамтран ярилцаж, уг хүний ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагадаа гүйцэтгэж байгаа үүрэг, байгуулсан гэрээ, хэлцлийн байдлыг нь үндэслэн аль тохирох хариултын арын кодыг дугуйлна.

Ажил эрхлэлтийн байдал гэдэг нь ажил эрхэлж байгаа хүний ажилладаг байгууллага буюу бусад хүмүүстэй байгуулсан гэрээгээр тодорхойлогдох ба өөрийн ажлын байртай холбогдох түүний байр суурь болон байгууллага бусад хүмүүстэй харилцах эрх мэдлийн хэр хэмжээний байдлын хэлбэр юм.

Хэрэв тоолуулагч хоёр өөр төрлийн ажил эрхэлж, түүний ажил эрхлэлтийн байдал нь ялгаатай байвал ажлын цагийн ихэнхийг өнгөрөөдөг ажлынх нь ажил эрхлэлтийн байдлаар нь бичнэ. Хэрэв яг ижил цаг зарцуулж байвал орлогын ихэнхийг олдог ажлынх нь ажил эрхлэлтийн байдлыг бичнэ.

**А. "Гэрээгээр ажиллагч-1"**

Аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээ, төрөл, өмчийн хэлбэрээс үл хамааран байгууллагынхаа удирдлагатай хийсэн гэрээ, хэлэлцээний (гэрээний хугацаа, хэлбэр хамаарахгүй) үндсэн дээр, тэдгээрийн баталсан удирдамж, дүрэм, журмын дагуу ажил эрхэлж, цалин хөлс авдаг хүмүүсийг гэрээгээр ажиллагчид гэнэ. Энд гэрээ нь чухал биш, хамгийн гол шалгуур нь тухайн хүн ажил, хөдөлмөр эрхэлснийхээ төлөө цалин авч байгаад оршино.

Гэрээгээр ажиллагчдад доорх ажиллагчдыг хамруулна.

1. **Төр, захиргаа, төсвийн байгууллагын бүх албан хаагчид**

*Төр, захиргаа, төсвийн байгууллагад ажилладаг, томилогдсон буюу сонгогдсон, хүнийг ажилд авах буюу халах эрх мэдэлтэй, тухайн байгууллагын үйл ажиллагааны талаар шийдвэр гаргах эрхтэй, түүнтэй холбогдсон хариуцлага хүлээдэг хүмүүсийг (яамдын сайд нар, засаг дарга нар гэх мэт) ажил олгогч гэж үзэхгүй. Учир нь эдгээр хүмүүс нь улсын төсвөөс цалин авч, төрийн өмчтэй газарт ажиллаж байгаа юм. Харин өөрийн эзэмшлийн өмч хөрөнгөтэй байгууллагад хүн авч ажиллуулж байгаа биш гэдгийг ойлгох хэрэгтэй.*

2. **Аж ахуйн нэгжид цалин хөлстэй ажиллагчид, Үүнд:**

•Хувийн компани, хоршоо, нөхөрлөл, хувиараа эрхлэх аж ахуйд ажиллагчид, дагалдан ажиллагчид буюу суралцагчид (хувийн компани, хоршоо, нөхөрлөл, хувиараа эрхлэх аж ахуйн эзэн, хоршооны гишүүд энд орохгүй).

•Улсын үйлдвэрийн газар, компанид ажиллагчид, дагалдан ажиллагчид буюу суралцагчид

- Хувь хүнтэй гэрээгээр ажиллагчид

**3. Төрийн бус байгууллагын ажиллагчид, Үүнд:**

•Үйлдвэрчний эвлэл, улс төрийн нам, хөдөлгөөн гэх мэт олон нийтийн байгууллагад ажиллагчид

- Шашны байгууллагад ажиллагчид, сүм, хийдийн лам, хуврага
- Буяны болон хүмүүнлэгийн байгууллагад ажиллагчид
- Бусад төрийн бус байгууллагад ажиллагчид

**Б. "Ажил олгогч-2"**

Биеэ даасан аж ахуйн нэгж, байгууллагын өмчийг бүхэлд нь буюу дийлэнхийг эзэмшдэг, нэг болон түүнээс олон хүнийг гэрээгээр тогтмол авч ажиллуулдаг, аж ахуйн нэгж, байгууллагаа төлөөлж гэрээ хэлцэл байгуулах эрх мэдэлтэй, түүний үйл ажиллагааныхаа талаар шийдвэр гаргаж, шийдвэр гаргах эрхийг бусдад олгох эрхтэй, аж ахуйн нэгж, байгууллагынхаа талаар хариуцлага хүлээдэг хүнийг **ажил олгогч** гэж үзнэ. Жишээлбэл, хувийн компани, нөхөрлөл, хоршоо, хувиараа эрхлэх аж ахуйн эзэн-захирал ажил олгогч болно. Харин эзэн нь биш, сонгогдсон буюу томилогдсон захирал бол ажил олгогч биш, гэрээгээр ажиллагч болно. Хэрэв өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг өрх тогтмол хүн авч ажиллуулдаг, жишээлбэл, малтай айл өөр өрхөд мөнгөн болон биет хэлбэрээр хөлс өгч малаа маллуулдаг бол **хувиараа ажиллагч** биш харин **ажил олгогч** болно.

**в. "Хувиараа ажиллагч-3"**

Үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг орлогоос (ашиг орлого олох боломжоос) тухайн хүний цалин орлого нь шууд хамаардаг, ашиг орлого нь тухайн хүний хувийн хэрэглээний нэг хэсэг болдог, үйлдвэрлэл үйлчилгээний үйл ажиллагаанд нөлөөлөх, түүний хөгжил дэвшлийн төлөө шийдвэр гаргадаг, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа бусад түнштэй хамтран ажиллаж болдог, богино хугацаагаар хүн авч ажиллуулж, цалин хөлс өгч болдог боловч тогтмол авч ажиллуулдаггүй хүнийг **хувиараа ажиллагч** гэнэ.
Үүнд: Хүнийг тогтмол авч ажиллуулдаггүй дараах хүмүүс орно.

•Хувийн компани, нөхөрлөл, хоршоо, ХЭАА-н эзэн-захирал

•Өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг (өөр ашиг орлоготой үйл ажиллагаа эрхэлдэггүй) өрхийн тэргүүлэгч

•Зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй хувиараа ажил эрхэлж байгаа бүх хүмүүсийг хувиараа ажил эрхлэгч гэж үзнэ.

Жишээлбэл, мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг өрхийн тэргүүлэгчийг (өөр ашиг орлоготой үйл ажиллагаа эрхэлдэггүй) үйлдвэрлэлдээ тогтмол хүн авч ажиллуулдаггүй тохиолдолд хувиараа ажил эрхлэгч гэж үзнэ.

### г. “Хоршооллын гишүүн-4”

Үйлдвэрлэл үйлчилгээний хоршоололд өөрийн эд хөрөнгө, хөдөлмөрөө сайн дураар нэгтгэж, хоршооллынхоо үйлдвэрлэл, үйлчилгээг эрхлэн явуулах зохион байгуулалт, удирдлага, хяналт болон бусад үйл ажиллагаа, ашиг орлогоо хуваарилах зэрэг асуудлыг шийдвэрлэхэд бусад гишүүдтэйгээ тэгш эрхтэй оролцдог хүмүүсийг “**Хоршооллын гишүүн**” гэнэ. Хоршооллын гишүүн бус гэрээгээр ажиллагчид энд орохгүй.

### д. “Гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогч-5”

Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд оролцон ажиллаж цалин, хөлс авдаггүй хүмүүсийг **гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогч** гэнэ. Жишээлбэл, энэ бүлэгт дараах хүмүүс багтана.

1.Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг өрхийн тэргүүлэгчээс бусад (өөр цалин орлоготой хөдөлмөр эрхэлдэггүй) гишүүд

2.Тухайн өрхийн гишүүн биш боловч өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд нь оролцож тусалдаг хүмүүс. Хамаатан айлдаа мал маллахад нь туслаж гэрт нь амьдардаг хүмүүс энд орно.

### е. “Бусад-6”

Хэрэв тоологч ажил эрхэлдэг боловч түүнийг энэ хэсгийн "а"-гаас "д" -д заагдсан ажил эрхлэлтийн байдлын ангилалаар ангилах боломжгүй тохиолдолд энэ бүлэгт хамруулна. Зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй хувийн арилжаа наймаа, гутал засвар гэх мэт ажил эрхлэж байгаа хүмүүсийг энд оруулахгүй. Ийм хүмүүсийг **хувиараа ажиллагч** гэсэн бүлэгт хамруулна.

Арваннаймдугаар асуултад хариулсан хүнээс арван есдүгээр асуултыг асуухгүй дараагийн хүнээс эхлэн асууна.

АРВАН ЕСДҮГЭЭР АСУУЛТ

**Та яагаад ажил эрхлэхгүй байна вэ?**

Тооллогын хуудасны 15-р асуултад "Үгүй-2" гэж хариулсан хүнээс энэ асуултыг асууна.

Тоологч тоолуулж байгаа хүнтэй сайтар ярилцаж, уул хүний ажил эрхлэхгүй байгаа шалтгааны аль тохирох ганцхан кодыг дугуйлна.

**а. "Сургуульд сурдаг-1"**

Ерөнхий боловсролын сургууль, бусад бүх шатны сургууль, дамжаанд суралцдаг, энэ нь ажил эрхлэхгүй байгаа гол шалтгаан нь болж байгаа хүмүүсийг энд хамруулна. Энэ хариулт нь "Та одоо сургуульд сурдаг уу?" гэсэн 13-р асуултаас зорилгын хувьд ялгаатай. 13-р асуулт нь бүх шатны сургуульд хамрагдалтыг тодруулах зорилготой байхад 19-р асуултын "Сургуульд суралцдаг" гэсэн хариулт нь тухайн хүний ажил эрхлэхгүй байгаа шалтгааныг тодруулж байгаа юм.

**б. "Тэтгэвэр, нөхөн олговорт-2"**

Өндөр насны тэтгэвэрт энгийн болон хөнгөлөлттэй, тусгай нөхцлөөр гарсан эсхүл нөхөн олговор авдаг, ажил эрхлэхгүй байгаа хүмүүсийг үүнд хамруулна.

**в."Өвчтэй, тахир дутуугийн группт-3"**

Өвчний эсхүл тахир дутуугийн групптэйн улмаас ажил эрхлэхгүй байгаа хүмүүсийг энд хамруулна.
Өвчний болон гэмтсэний улмаас тооллогын өмнөх 7 хоногт түр ажиллахгүй байгаа боловч ажилладаг байгууллагатайгаа хөдөлмөрийн гэрээгээ цуцлаагүй, тодорхой хугацааны дараа ажилдаа эргэн орох хүмүүс **ажил эрхэлдэг хүн амд** орно.

**г. "Гэрийн ажилтай-4"**

Бага насны хүүхэд, өвчтөн, өндөр настан асардаг, гэр бүлийн хүний ажлын онцлогоос шалтгаалан ажил эрхлэдэггүй, зөвхөн гэрийн ажил хийдэг хүмүүсийг энд хамруулна.

*Жирэмсний болон хүүхэд төрүүлсний амралт, 2 хүртэлх насны хүүхдээ асардаг захирганы чөлөөтэй байгаа хүмүүс, цалин хөлстэйгээр гэрийн үйлчлэгч хийж байгаа хүмүүс, биет хэмжээний болон мөнгөн орлого олох зорилгоор гэртээ ажил хийдэг хүмүүс* ***ажил эрхэлдэг хүн амд*** *орно.*

**д. "Тохирох ажил олдохгүй байгаа-5"**

Ажил хийхийг хүсч байгаа, ажил хийхэд бэлэн, урд нь ажил идэвхтэй хайж байгаад тохирох ажил олдохгүй итгэл алдарсны улмаас тооллогын өмнөх 7 хоногт ажил идэвхтэй хайгаагүй, эсвэл тохирох ажлыг хаана хайхаа мэдэхгүй байгаа, өөрөө тохирох ажил олдохгүй гэж үзэж байгаа хүмүүсийг энд хамруулна.

**е. "Ажил хайж байгаа-6"**

Тооллогын өмнөх 7 хоногт ажил эрхлээгүй, ажил хайж байгаа хүмүүсийг **ажил хайж байгаа** гэж нөхнө.

**ё. "Бусад-7"**

Зааврын энэ хэсгийн "а"-гаас "е"-д заагдснаас өөр шалтгаанаар ажил хийхгүй байгаа хүмүүсийг энд хамруулна.

## Тооллогын хуудасны 15-19 дүгээр асуултуудын хариултыг нөхөх загвар

Тоологч **"Эрхэлдэг ажил"**, **"Үйл ажиллагааны үндсэн чиглэл"** зэрэг асуултад кодлогчид ойлгомжтой, ерөнхий биш, кодлоход амар хариултыг нөхөх шаардлагатай. **"Эрхэлдэг ажил"** дээр "багш", **"Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл"** асуултад "Хувийн компани" гэх мэт тодорхой бус хариулт нөхөх, эсвэл "Алтжин" ХК гэх мэтээр зөвхөн байгууллагын нэр бичиж болохгүй юм.

Та бүхэнд улам бүр ойлгомжтой болгох зорилгоор дараах жишээг толилуулж байна.

**А. Тоолуулагчийн эрхэлдэг ажил, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг сайн тодруулан асууж бөглөх хэрэгтэй. Жишээлбэл:**

1. Тоолуулагч эрхэлдэг ажлаа "*менежер*" хийдэг, аж ахуйн нэгж байгууллагынхаа үйл ажиллагааны үндсэн чиглэлийг "*үйлдвэр, худалдаа*" гэж хариулж болно. Энэ тохиолдолд тоологч тухайн хүний эрхэлдэг ажлыг *ерөнхий менежер, эсвэл борлуулалт хариуцсан менежер үү, ямар хэлтэс тасагт ажилладаг вэ,* гэсэн байдлаар, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг "*танай байгууллага ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалддаг вэ?*" гэсэн байдлаар лавлаж асуугаад хариултыг үндэслэж доорх маягаар нөхнө.

| | |
|---|---|
| 15. Та сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн үү? Тийм -1 Үгүй -2 | (1) 2 |
| 16. Эрхэлдэг ажил | РЕКЛАМ СУРТАЛЧИЛГАА ХАРИУЦСАН МЕНЕЖЕР<br>☐☐☐☐ |
| 17. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл | ХИАМНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ ХУДАЛДАА<br>☐☐☐ |
| 18. Ажил эрхлэлтийн байдал<br>Гэрээгээр ажиллагч -1<br>Ажил олгогч -2<br>Хувиараа ажиллагч -3<br>Хоршооллын гишүүн -4<br>Гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогч -5<br>Бусад -6 -6 | (1) 4<br>2 5<br>3 6 |

Энэ хүнээс *та цалин хөлс авдаг уу, эсвэл та өөрийнхөө байгууллагын эзэн үү?* гэсэн байдлаар тодруулан асууж хэрэв тухайн хүн тус байгууллагын өмч хөрөнгийг эзэмшээгүй, цалин хөлс авч ажиллаж байгаа бол түүний ажил эрхлэлтийн байдал нь "Гэрээгээр ажиллагч" болно.

2.Тоолуулагч өөрийн ажилладаг байгууллагын үндсэн чиглэлийг "*худалдаа*", өөрөө *худалдагч* гэж хариулж болно. Энэ тохиолдолд тоологч ямар худалдаа эрхэлдэг, бөөний эсхүл жижиглэн худалдааны аль нь болох, мөн юуны худалдаа эрхэлдэг зэргийг маш сайн асуух хэрэгтэй. Жишээлбэл, тоолуулагч хүнсний ногооны бөөний худалдаа хийдэг гэж хариулсан тохиолдолд "***Хүнсний ногооны бөөний худалдаа***", зах дээр гутлын жижиглэн худалдаа эрхэлдэг гэж хариулсан тохиолдолд "***Зах дээр гутлын жижиглэн худалдаа эрхэлдэг***" гэх мэтээр нөхнө.

| | |
|---|---|
| 15. Та сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн үү? Тийм -1 Үгүй -2 | (1) 2 |
| 16. Эрхэлдэг ажил | ХҮНСНИЙ НОГООНЫ ХУДАЛДАГЧ |
| 17. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл | ХҮНСНИЙ НОГООНЫ БӨӨНИЙ ХУДАЛДАА |
| 18. Ажил эрхлэлтийн байдал<br>Гэрээгээр ажиллагч -1<br>Ажил олгогч -2<br>Хувиараа ажиллагч -3<br>Хоршооллын гишүүн -4<br>Гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогч -5<br>Бусад -6 | (1) 2 3 4 5 6 |

Дээрх жишээний дагуу тухайн хүн бөөний худалдааны газар хүнсний ногооны худалдагч тул түүний ажил эрхлэлтийн байдал бараг тодорхой байна. Учир нь тэрээр худалдагч хийж цалин авч байгаа гэсэн үг. Гэхдээ хүнсний ногооны бөөний худалдаа эрхэлдэг газрын өмчийг хэн эзэмшдэг болохыг тодруулаад хэрэв тухайн хүний хөрөнгө биш бол түүний ажил эрхлэлтийн байдлыг "Гэрээгээр ажиллагч" гэж авна.

3. Нарийн мэргэжлийн ажилчдын **эрхэлдэг ажил**-ыг өөрсдийнх нь мэргэшсэн ажлаар тодорхой бичих шаардлагатай. Тоологч тухайн хүн *операторч* гэж хариулбал зөвхөн ***операторч*** гэж бичих нь хангалтгүй бөгөөд ямар машин тоног, төхөөрөмжийн мэргэшсэн операторч болохыг нь тодорхой бичих шаардлагатай. Жишээ: Хөтөлийн цементийн үйлдвэрийн цемент үйлдвэрлэх тоног төхөөрөмжийн операторчийн хувьд доорх маягаар нөхнө.

| | |
|---|---|
| 15. Та сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн үү? Тийм -1 Үгүй -2 | (1) 2 |
| 16. Эрхэлдэг ажил | ЦЕМЕНТ ҮЙЛДВЭРЛЭХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ОПЕРАТОРЧ |
| 17. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл | ЦЕМЕНТ ШОХОЙН ҮЙЛДВЭРЛЭЛ |
| 18. Ажил эрхлэлтийн байдал<br>Гэрээгээр ажиллагч -1<br>Ажил олгогч -2<br>Хувиараа ажиллагч -3<br>Хоршооллын гишүүн -4<br>Гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогч -5<br>Бусад -6 | (1) 2 3 4 5 6 |

Дээрх жишээнээс харахад эрхэлдэг ажил, үйл ажиллагааны үндсэн чиглэлээс тухайн хүн үйлдвэрт цалин хөлстэй ажил эрхэлдэг нь тодорхой байна. Иймд түүний ажил эрхлэлтийн байдал нь " Гэрээгээр ажиллагч" болно.

## Б. Хэрэв тоолуулагч хоёр ажил эрхэлдэг тохиолдолд ажил эрхлэлттэй холбоотой асуултуудыг бөглөх жишээ

1.Тоолуулагч тооллогоос өмнөх 7 хоногт нэгээс илүү ажил эрхэлсэн бол тооллогын хуудсанд **үндсэн ажил**-аар нь нөхнө. **Үндсэн ажил** гэдэг нь тооллогоос өмнөх 7 хоногт хамгийн олон цаг ажилласан ажил юм. Ажилласан цаг нь яг ижил бол хамгийн их орлого олж байгаа ажил юм. Жишээ нь: Тоолуулагч Дулмаа нэгэн арилжааны банкны салбарт ерөнхий нягтлан бодогч хийхийн хамт жижиг хувийн дэлгүүрийн нягтлан бодогчоор давхар ажилладаг бол доорх маягаар нөхнө. Эрхэлдэг ажилд өөрийнх нь хэлснээр "Ерөнхий нягтлан бодогч", харин Үйл ажиллагааны үндсэн чиглэл нь ***"Мөнгөний гүйлгээний үйл ажиллагаа***" гэсэн байдлаар бичнэ.

| | |
|---|---|
| 15. Та сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн үү? Тийм -1 Үгүй -2 | (1) 2 |
| 16. Эрхэлдэг ажил | ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ<br>☐☐☐☐ |
| 17. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл | МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГАА<br>☐☐☐ |
| 18. Ажил эрхлэлтийн байдал<br>Гэрээгээр ажиллагч -1<br>Ажил олгогч -2<br>Хувиараа ажиллагч -3<br>Хоршооллын гишүүн -4<br>Гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогч -5<br>Бусад -6 -6 | (1) 4<br>2 5<br>3 6 |

Тоолуулагч Дулмаагийн эрхэлдэг ажлаас цалин, хөлстэй ажил хийдэг нь тодорхой байна. Гэхдээ тоолуулагч Дулмаагаас түүний ажилладаг газрын хөрөнгийг хэн эзэмшдэгийг тодруулж асуугаад, хэрэв түүнд хамаагүй бол түүний ажил эрхлэлтийн байдлыг "Гэрээгээр ажиллагч" гэж авна.

## В. Хэрэв тоолуулагч хувиараа ажил эрхэлдэг бол ажил эрхлэлтийн асуултуудыг нөхөх жишээ

1. Өрхийн үйлдвэрлэл (мал аж ахуй, газар тариалан гэх мэт) эрхэлдэг өрхийн тэргүүлэгчээс бусад, 15-аас дээш настай, өөр цалин хөлстэй ажил эрхэлдэггүй гишүүний хувьд ажил эрхлэлтийн 15-18 дугаар асуултуудыг дараах байдлаар нөхнө.

| | |
|---|---|
| 15. Та сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн үү? Тийм -1 Үгүй -2 | (1) 2 |
| 16. Эрхэлдэг ажил | МАЛЧИН |
| 17. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл | МАЛ АЖ АХУЙ |
| 18. Ажил эрхлэлтийн байдал<br>Гэрээгээр ажиллагч -1<br>Ажил олгогч -2<br>Хувиараа ажиллагч -3<br>Хоршооллын гишүүн -4<br>Гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогч -5<br>Бусад -6 -6 | 1 4<br>2 (5)<br>3 6 |

Эдгээр хүмүүс нь тухайн өрхийнхөө үйлдвэрлэлд оролцоод цалин авахгүй байгаа тул түүний ажил эрхлэлтийн байдал нь "гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогч" гэж авна. Эдгээр хүмүүсийн ажил эрхлэлтийн байдлыг "хувиараа ажиллагч" гэж авч болохгүй. Учир нь эдгээр хүмүүс өрхийнхөө үйлдвэрлэлд оролцож байгаа болохоос биш биеэ даасан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулаагүй байгаад оршино.

2. Хэрэв тухайн өрх мал маллахдаа өөр өрхийн гишүүдийг тогтмол хөлслөн, мөнгөн болон биет хэлбэрээр цалин хөлс өгч ажиллуулдаг бол өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн байдал нь хувиараа ажиллагч биш харин ажил олгогч болж байна.

| | |
|---|---|
| 15. Та сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн үү? Тийм -1 Үгүй -2 | (1) 2 |
| 16. Эрхэлдэг ажил | ЭЗЭН |
| 17. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл | МАЛ АЖ АХУЙ |
| 18. Ажил эрхлэлтийн байдал<br>Гэрээгээр ажиллагч -1<br>Ажил олгогч -2<br>Хувиараа ажиллагч -3<br>Хоршооллын гишүүн -4<br>Гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогч -5<br>Бусад -6 -6 | 1 4<br>(2) 5<br>3 6 |

1.Ямар нэг албан ёсны зөвшөөрөлгүй, жижиг худалдаа, гар урлал, үйлчилгээ эрхлэгчдийн ажил эрхлэлтийг дараах байдлаар нөхнө. Эдгээр хүмүүсийн ажил эрхлэлтийн байдал нь "хувиараа ажиллагч" байна. Учир нь эдгээр хүмүүс өөрийн гэсэн биеэ даасан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаад оршино. Жишээлбэл, тоолуулагч эрхэлдэг ажлаа *машин угаадаг* гэж хариулбал түүний ямар машин хаана угаадаг болохыг тодруулан асууж *автомашин угаадаг* болохыг тодруулж авах хэрэгтэй.

| | |
|---|---|
| 15. Та сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн үү? Тийм -1 Үгүй -2 | (1) 2 |
| 16. Эрхэлдэг ажил | АВТОМАШИН УГААГЧ |
| 17. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл | ГУДАМЖИНД АВТО МАШИН УГААДАГ |
| 18. Ажил эрхлэлтийн байдал<br>Гэрээгээр ажиллагч -1<br>Ажил олгогч -2<br>Хувиараа ажиллагч -3<br>Хоршооллын гишүүн -4<br>Гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогч -5<br>Бусад -6 -6 | 1 4<br>2 5<br>(3) 6 |

## 4. Байр, орон сууцны төрөл, нөхцлийн холбогдох асуултыг нөхөх тухай

### а. Сууцны төрөл

**1.** Тоологч орон сууцны холбогдох асуултуудыг нөхөхийн өмнө тэр орон сууцанд (гэрт), хэдэн өрх амьдарч байгаа, сууцны төрөл нь байшин, гэрийн аль нь болохыг тодруулж, аль тохирохыг дугуйлна. Гэрт суудаг-2 гэж хариулбал шууд 11-р асуултаас эхлэн асууна

Тухайн өрх, сууцны хоёроос дээш тооны байшин, гэр, эсвэл байшин, гэр хоёуланг эзэмшдэг тохиолдолд тоологч хүйтний улиралд, эсвэл аль олон хүн оршин суудаг сууцаар нь тооллогын хуудсыг нөхнө.

Хэрэв зориулалтын зураг төсөлгүйгээр хувийн журмаар барьсан 2- оос дээш байшинд уг өрх суудаг бол сууж байгаа байшингуудыг бүхэлд нь нэг сууц гэж үзэж, өрөөний тоо, дэд бүтцийнх нь хангамжийн байдлаар тооллогын хуудсыг нөхөж болно. Дэд бүтэцийн хангамжинд халаалтын төрөл, усан хангамж, хог зайлуулалт, бие засах газар зэрэг орно.

### Байшин

**2. Сууцны зориулалт.** Өрх, хүн амын сууж байгаа байшинг зориулалтаар нь сууцны зориулалтын тусдаа байшин, нийтийн сууцны байшин доторхи орон сууц, оюутан, сурагчдын нийтийн байр, ажиллагчдын нийтийн байр, нийтийн эзэмшлийн бусад байр, сууцны бус, бусад гэж 7 ангилна.

**а.Сууцны тусдаа байшин.** Орон сууцны зориулалтын зураг төслөөр баригдсан, зориулалтын зураг төсөлгүй боловч иргэд өөрсдөө сууцанд зориулж барьсан нэг буюу хэд хэдэн

өрх суухад зориулан тохижуулан тоноглогдсон, дэд бүтцийн холбогдох хангамжтай сууцны байшинг үүнд хамруулна.

**б. Нийтийн сууцны байшингийн доторх орон сууц.** Зориулалтын зураг, төслөөр баригдсан, бүтэц хийцийн хувьд хоёроос дээш айл суухад зориулан, төхөөрөмжлөгдсөн (байшингийн хэмжээ, давхар, хэдэн айл суух зориулалттайгаас үл хамааран), дэд бүтцийн хангамжтай байшинг нийтийн орон сууцны байшин гэнэ. Нийтийн сууцны байшин дотор өрх тус бүрт зориулагдсан тусдаа нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, тоноглол, төхөөрөмжтэй бусад айлаас тусгаарлагдсан зориулалтын ханатай (хаалттай), нэгдсэн шат, хонгил, эсвэл гудамж, хашаа руу шууд гарах хаалгатай нэг айл суухад зориулагдсан сууцыг **нийтийн сууцны байшингийн доторх орон сууц гэнэ.**

**в. Оюутан, сурагчдын нийтийн байр.** Бүх шатны сургуулийн оюутан, сурагчдын дотуур байр, түүнтэй адилтгах бусад нийтийн байр (тусгай сургуулийн болон хүүхдийн зуслан амралтын гэх мэт)-ыг оюутан сурагчдын нийтийн байр гэж үзнэ.

**г. Ажиллагчдын нийтийн байр гэж** аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчид хамтран (ураг төрлийн болон гэр бүлийн холбоогүй) буюу ганц нэгээрээ суухад зориулагдсан нийтийн байрыг хэлнэ.

**д. Нийтийн эзэмшлийн бусад байр.** Амралт сувилал, эмнэлэг, асрамж тэтгэмжийн газар, шорон, цэргийн хүрээ зэрэг хүмүүс бөөнөөрөө буюу хэсэг бүлгээрээ суух нийтийн байрыг үүнд хамааруулна.

**е. Сууцны бус.** Анхнаасаа хүн суух зориулалтын бус байшин, түүний нэг хэсэг буюу өрөө тасалгаанд (зориулалтаараа аж ахуйн нэгж, байгууллага байрлахад зориулагдсан гэх мэт) болон вагончик гэх зэрэгт өрх айл, хүн сууж байгаа бол сууцны бус байшин гэж үзнэ.

**з. Бусад.** Тооллогын үед өрх, айл, хүн амын сууж байгаа байр, сууц нь энэ хэсгийн "а"-аас "е"-д заасныг бусад төрлийн тухайлбал, байшингийн дээвэр, хонгил, орц, дулааны шугам сүлжээ, ой мод, уул хад зэрэгт амьдарч байвал энэ хэсэгт хамруулна.

**3. Өрөөний тоо.** Сууцны өрөөний тоог зөвхөн тоогоор (01,02,03,04 гэх мэт) асуултын арын дөрвөлжин нүдэнд нөхнө. Сууцны өрөөний тоонд зөвхөн унтах, амрах, зочны, ажлын гэх мэт өрөөнүүдийг оруулах бөгөөд харин гал зуух, онгоц, шүршүүр болон ариун цэврийн, ханын хувцас эд хогшил хадгалахад зориулсан өрөөнүүд орохгүй.

**4. Сууцны талбай.** Орон сууцны унтах амрах, зочин, ажлын өрөөнүүдийн талбайн нийлбэрийг "Сууцны талбай" гэнэ. Өөрөөр хэлбэл сууцны хөлс төлж байгаа талбай нь сууцны талбай болно. Хувийн журмаар барьсан гал зуухны өрөөгүй сууцны "Сууцны талбай"-г гаргахдаа ашигтай талбайгаас гал зуухны хэсгийн талбайг хасч тооцно. Тоолуулагч сууцныхаа талбайг мэдэхгүй тохиолдолд сууц эзэмшигчийн гэрээ , орон сууц өмчлөх эрхийн гэрчилгээ зэргийг үзэхийг зөвлөж болно. Хувиараа барьсан сууцны хувьд эздээр нь хэмжүүлэх зэрэг сууцны талбайгаа үнэн тодорхойлох боломжтой аргуудыг хэрэглэхийг тоологч зөвлөх хэрэгтэй.

**5. Халаалт.** Орон сууцны байшингийн халаалтыг эх үүсвэрийнх нь хувьд "Төвлөрсөн","Төвлөрсөн бус","Бусад" гэж гурав ангилна.

**а.төвлөрсөн халаалттай.** Дулааны цахилгаан станц болон төвлөрсөн уурын зуухтай холбогдсон дулааны сүлжээтэй сууцыг төвлөрсөн халаалттай гэж үзнэ.

**б. төвлөрсөн бус халаалттай.** Тусгайлан барьсан уурын зуухтай холбогдсон дулааны сүлжээтэй буюу өөрийн бие даасан дулааны сүлжээтэй сууцыг төвлөрсөн бус халаалттай сууц гэнэ.

**в. бусад**. Ердийн зуух, пийшин зэргээр халаадаг сууцыг бусад гэдэгт хамруулна.

**6.Усан хангамж.** Орон сууцны усан хангамжийг халуун, хүйтэн усны сүлжээтэй, зөвхөн хүйтэн усны сүлжээтэй, байшингийн гаднаас зөөврөөр хангагддаг гэж 3 ангилна. Гэхдээ усаа зөөврөөр хангадаг өрхүүдийн хувьд ус зөөдөг хэрэгслэлийн төрөл, хэлбэрээс үл хамааран ус авч байгаа цаад эх үүсвэрийг нь гүний худаг (зураг төслийн дагуу малтаж баригдсан, мотор буюу бусад төхөөрөмжөөр усаа авдаг худаг), уурхайн (Иргэд өөрсдөө малтсан энгийн худаг) худаг, бусад гэсэн 3 хариултын аль тохирохыг нь авна. Хэрэв олон эх үүсвэрээс авдаг бол аль илүү түлхүүхэн авдаг эх үүсвэрийг нь сонгоно.

**7.Хог зайлуулалт.** Хог, хаягдлыг хоолойгоор, төвлөрсөн цэгт эсвэл өрх айл өөрсдөө ганцаараа цуглуулж зайлуулдаг, мөн хог хаягдлыг цуглуулж зайлуулах тодорхой цэг байхгүй гэсэн хариултаас аль тохирохыг сонгоно. Хоолойгоор хогоо зайлуулдаг гэдэгт томоохон хот суурин газрын гол төлөв угсармал орон сууцны орц бүрд хог зайлуулах зориулалтын хоолоотой сууцыг хамруулна.

**8. Бие засах газар.** Тухайн сууцны бие засах газрыг сууц дотроо гэхдээ тэр нь тусдаа, нийтийн эсэх, сууцны гадна гэж ангилсны аль тохирохыг нь сонгож, холбогдох кодыг дугуйлна.

**9. Гал тогооны өрөө.** Гал тогооны тусдаа өрөөтэй, өрөөгүй, нийтийн өрөөтэй гэсэн 3 хариултын аль тохирохыг сонгож, холбогдох кодыг дугуйлна.

**10. Онгоц, шүршүүрийн өрөө.** Онгоц, шүршүүрийн тусдаа өрөөтэй, өрөөгүй, нийтийн гэсэн 3 хариултаас аль тохирохыг сонгоно.

**Гэр.**

**11. Гэрийн тоо.** Нэг өрх хэд хэдэн гэрт амьдарч болно. Энэ асуултанд тоолуулж байгаа өрхийн гэрийн тоог бичнэ. "Цаатан"-гуудын суудаг урцыг гэрт хамруулна.

**12. Ханын тоо.** Тооллогын үед айл, өрхийн сууж буй гэрийн ханын тоог толгойн тоог харгалзахгүйгээр зориулалтын дөрвөлжинд бичнэ. Хэрэв тухайн өрх 2 гэртэй бол зөвхөн үндсэн гэрийн ханын тоог бичнэ. Үндсэн гэр гэдэгт өвлийн улиралд голлон суудаг гэр эсвэл аль олон хүн суудаг гэрийг хамруулна Цаатангуудын урцны хувьд ханын тоо гэсэн дөрвөлжинд "05" гэж бичнэ.

**Гэрийн ахуйн нөхцөл**

**12.Усан хангамж.** Өрх хэрэгцээт цэвэр усаа хаанаас авдгийг эх үүсвэрээр нь тодорхойлж, хариултын аль тохирох кодыг дугуйлна. Хэрэв өрх зөөврийн (зөөх хэрэгслийн төрөл, хэлбэрээс үл хамаарна) устай бол түүний үндсэн эх үүсвэрээр нь нөхнө.

**14. Хог зайлуулах зориулалтын цэгтэй эсэх.** Хог хаягдлыг зориулалтын цэгт асгаж , зайлуулдаг бол "тийм", бусад тохиолдолд "үгүй" гэдгийн холбогдох кодыг дугуйлна.

**15.Бие засах зориулалтын цэгтэй эсэх.** Бие засахад зориулсан, хаалт хамгаалалт бүхий тусгай цэгтэй, үгүй хоёрын аль тохирохоор нь "тийм". "үгүй" гэдгийн тохирох кодыг дугуйлна.

**16.Бохир усны зориулалтын цооногтой эсэх.** Бохир усны зориулалтын цооногтой (муу усны нүхтэй), үгүйн аль тохирох кодыг дугуйлна.

**Бүх өрх нөхөх асуулт**

Тооллогын хуудасны байр, орон сууцны төрөл, нөхцлийн 17-19 -р асуултуудыг сууц, гэр, байрны төрөл хэлбэрээс үл хамааран бүх өрхөөс асууж нөхнө.

**17.Сууцны өмчлөл .** Орон сууц, гэр, байрыг өмчийнх нь харъяаллаар төрийн, хувийн, холимог гэж 3 ангилна.

**а.Төрийн.** Төрийн болон төрийн өмч давамгайлсан(төрийн өмч нь 51 хувиас дээш) аж ахуйн нэгж, байгууллагын мэдлийн сууц (сууж байгаа өрх сууцаа хувьчилж аваагүй), гэр , байр үүнд хамруулна.

**б.Хувийн.** Хүмүүс өөрөө барьсан хувийн орон сууц, нийтийн сууцны байшин дахь хувьчилж авсан орон сууц, мөн хувийн хэвшлийн аж ахуйн нэгж , байгууллагын (Өмчийнх нь 51 хувиас дээш хувийн өмчтэй) мэдлийн сууц, гэр үүнд хамаарна.

**в. Холимог.** Төрийн, хувийн өмч холимог (адилхан 50 хувийн өмчтэй ) аж ахуйн нэгж ,байгууллагын мэдлийн байр, сууц, гэрийг үүнд хамруулна.

**18,19. Сууц (гэрийн) цахилгаан тэрэлтэй, телефон утастай** эсэхийн аль тохирох кодыг дугуйлна.

**Тоологч өрх, ам бүлийн жагсаалтанд бичигдсэн бүх хүнийг бүрэн тоолсон эсэхээ эцэст нь дахин дахин нягтлан шалгаж хэрэв хүн дутуу үлдээсэн, хүнийг давхардуулан тоолсон, мөн гаднаас ирсэн тоологдох ёстой хүн үлдсэн эсэхийг дахин шалгах хэрэгтэй.**

**Орон сууцны нөхцлийн холбогдох үзүүлэлтийг бүрэн зөв хариулсан ялангуяа суудаг өрхийн тоо, байнга суугчдын тоог зөв бөглөсөн эсэхээ дахин нэг шалгаж, тодорхойгүй, буруу зөрүү хариулагдсан асуулт байвал тоолуулагчаас дахин лавлаж зөв болгосны дараа тооллогын хуудсанд гарын үсгээ зурж, тоолсон өдрөө бичсэний дараа тоолуулж байгаа өрхөөс дараагийн тоолуулах өрхөд шилжих хэрэгтэй.**

## 5. Тооллогын хуудасны нөхөлтийн үнэн зөвийг шалгах заавар

Хүн ам, орон сууцны тооллогын хуудасны нөхөлтийн үнэн зөвийг шалгахад дараах зүйлийг анхаарч ажиллана. Үүнд:

1.Тооллогын хуудасны асуулт бүр хариулагдсан эсэхийг нэн тэргүүн шалгана.

2.Тооллогын хуудас үргэлжлэлтэй эсэхийг нүүрний хэсэг дэхь тоологдсон хүний болон тооллогын хуудасны тоотой уялдуулан шалгана.

3.Тооллогын хуудасны бүх асуултын хариултыг туйлын анхааралтай үзэж шалгана. Тодорхой нас зааж хариулах зарим асуулт, түүнчлэн алгасах ёстой асуултуудаас бусад бүх асуултыг тоологдсон хүн бүр хариулсан байх ёстой. Насны бүлгээр ялгаатай хариулагдах тооллогын хуудасны асуултыг хүснэгтээр үзүүлбэл:

| Тооллогын хуудасны асуултын дугаар | Ямар насны хүмүүст нөхөгдөх |
|---|---|
| 1-8 | Бүх хүмүүс |
| 9 | 8-р асуултад шилжиж ирсэн гэж хариулсан бүх хүмүүс |
| 10 | 5-аас дээш настай бүх хүн |
| 11-12 | 7-оос дээш настай бүх хүн |
| 13 | 7-29 настай хүмүүс |
| 14-19 | 15-аас дээш настай бүх хүн |

4.Асуултын хариултыг шалгахдаа логик, бодох, тооцоолох, харьцуулах аргыг хэрэглэнэ. Нэг асуултад олон хариултыг дугуйлсан байж болохгүй.

5.Тоогоор хариулагдах асуултын зохих тоог зөв дугуйлсан, нүдэнд багтаан тоог тавьсан, үгээр бичигдэх хариултыг гаргацтай бичсэн, хариултын зохих кодыг зөв авсан эсэхийг шалгана. Нүдэнд тавигдах тооны оронгийн тоо нь нүдний оронгийн тооноос бага байвал өмнө нь "0" тавьж урагш гүйцээж бичсэн байх ёстой.

6.Нэг асуултын хариулт авсны дараа нөгөө асуултад шилжих шилжилтийг зөв хийсэн эсэхийг харах. Жишээлбэл **Суурьшил** гэсэн 7-р асуултын байнга суудаг-1 гэж хариулсан тохиолдолд 8-р асуулт руу шилжинэ.

Мөн 14-р асуултанд **Та сүүлийн 7 хоног ажил эрхэлсэн үү ?** гэсэн асуултанд "Үгүй- **2**" хариулсан тохиолдолд асуулт 19-рүү шилжих ёстой.

7.Тооллогын комиссын дугаарыг Үндэсний статистикийн газраас баталж, хүргүүлснээс өөрөөр бичиж болохгүй. Шалгагч нь тодорхой нэг тооллогын комисс, түүний тоологч нарыг хариуцан ажиллаж байгаа учир тооллогын хуудсанд бичигдсэн тооллогын комиссын дугаар батлагдсан дугаартай таарч байгааг шалгана.

8."Байршил" гэсэнд зөвхөн нэг л код тавьсан байна.

9.Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр, кодыг Монгол Улсын засаг захиргааны жагсаалт Хавсралт -1, тосгоны нэр, кодыг Монгол Улсын хот, тосгоны жагсаалт Хавсралт -2-оос, яс үндэсний нэр, кодыг ястан үндэстний код, Хавсралт -3 -аас гадаадын улс, хотын нэр, кодыг дэлхийн улс орнуудын код Хавсралт- 4-өөс, тус тус харна.

10."Өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох" гэсэн асуултад өгсөн хариултыг бусад асуултын хариулттай уялдуулан шалгана.Үүнд:

а)өрхийн тэргүүлэгч гэр бүлээсээ салсан /эсвэл бэлбэсэн/ бол **02**-ыг дугуйлахгүй, **01**-ийг дугуйлна. Энэ нөхцөлд асуулт 14-т 5 эсхүл **6**-гийн аль тохирохыг дугуйлах ёстой.

б)"Тэргүүлэгч өөрөө" гэж хариулсан хүний нас 16-гаас дээш байх ёстой. Хэрэв зарим онцгой тохиолдолд 16 наснаас доош хүн өрхийн тэргүүлэгч гэж хариулсан бол манай ёс заншлаар тэр нь эрэгтэй хүүхэд байна уу, үгүй юу, ер нь энэ хариулт үнэн үү гэдгийг шалгах.

11.Асуулт 4-ийн хариултыг шалгахдаа дараах зүйлийг анхаарна. Үүнд:

а)төрсөн он, сараар бодоход нас нь тохирч байгаа, эсвэл насаар нь тооцоход төрсөн он, сар таарч байгаа эсэх,

б)нас, боловсролын түвшингийн асуулт уялдсан эсэх (7 настай гэж хариулсан байхад асуулт 11-д 2-7 –гийн аль нэг хариултыг дугуйлсан байж болохгүй),

в)нас, гэрлэлтийн байдлын хариулт уялдсан эсэх (жишээлэхэд 14 ба түүнээс доош настай гэж хариулсан байхад 14-р асуулт хариулагдах ёсгүй.

12.Аль улсын харъяат, яс үндэс гэсэн асуултыг зааврын дагуу нөхөж, ард нь кодыг тавьсан эсэх.

13. Түр эзгүй хүний түр сууж байгаа, түр сууж байга хүний байнга суудаг хаяг заавал бичигдэж, код тавигдсан байх ёстой.

14. 8-р асуултад шилжиж ирсэн-2 гэж хариулагдсан байвал шилжиж ирсэн аймаг, нийслэл /улс/-ийн нэр, шилжиж ирсэн он заавал тавигдсан байна. Энэ асуултад "төрснөөс хойш – 1" гэж хариулсан хүний хувьд 9,10-р асуултуудыг хариулахгүй. " Өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох" гэсэн асуултад 08 буюу эмэг эх/ өвөг эцэг гэж хариулсан хэрнээ 13 дугаар асуултад "Тийм-1" гэх буюу 19 дүгээр асуултад "1" гэж хариулсан байх ёсгүй.

15.Асуулт 11-т "боловсролгүй" гэж хариулсан хүн асуулт 12-ыг заавал хариулсан байх ёстой. Харин түүнээс өөр хариулт өгвөл асуулт 13 руу шилжиж асуусан байна.

16.Асуулт 14-д 15 ба түүнээс дээш настай хүн хариулах бөгөөд гэр бүлээ батлуулаагүй хүмүүсийн хувьд **3**-ыг дугуйлсан байх ёстой.

17.Асуулт 15-д 15 ба түүнээс дээш насны бүх хүн хариулсан байна. энэ асуултад "Сүүлийн 7 хоног ажил эрхэлсэн" гэж хариулсан хүмүүсийн хувьд тэдний ажил хийж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл, ажил эрхлэлтийн байдал зэрэг үзүүлэлтийг хооронд нь уялдуулан шалгана. Харин асуулт 15-д сүүлийн 7 хоног ажил эрхлээгүй гэж хариулсан хүмүүс асуулт 16-18-ыг хариулахгүй шууд асуулт 19-ыг хариулна.

18.Үргэлжлэл хуудастай эсэхийг шалгах. "ТИЙМ-1" гэж тэмдэглэсэн бол үргэлжлэл хуудас байгаа эсэх, эсвэл үргэлжлэл хуудас байгаа боловч "ҮГҮЙ-2" гэж тэмдэглэснийг үзнэ.

19. **Байр орон сууцны төрөл нөхцөл**-ийн асуулт 01-10-ыг зөвхөн байшинд суудаг өрхөөр, асуулт 11-16-г зөвхөн гэрт суудаг өрхөөр, харин асуулт 17-19-ийг бүх өрхөөр нөхөх учиртайг анхаарч шалгана. Зарим өрх байшин, гэр хсёуланд нь сууж байгаагаар хариулсан тохиолдолд тоологчосс сайн асууж, зааврын дагуу аль нэгээр нь нөхнө.

## Бүлэг YII. Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын материалыг хүлээн авах, явцын мэдээ болон урьдчилсан дүнг гаргах заавар

### а. Тооллогын явцын мэдээг гаргах

1. Хүн ам, орон сууцны тооллогын явцын мэдээг төв, суурин газар (нийслэл, аймгийн төв, сумын төв, тосгон)-ын тооллогын түр товчоод 2000 оны 1-р сарын 6-ны өдрөөс эхлэн дараах графикаар ҮСГ-т өгнө.

### А.Тооллогын явцын мэдээг гаргах график*




**Тооллогын явцын мэдээг 2000 оны нэгдүгээр сарын 6 -13-нийг дуустал өдөр бүр, эцсийн мэдээг нэгдүгээр сарын 15 -нд мэдээлнэ.**

## Б. Хөдөөгийн шалгагч нараас сумын түр товчоонд тооллогын явцын мэдээг өгөх хугацаа

| | | Мэдээлэх хугацаа |
|---|---|---|
| 1. | 5-7-ны мэдээг | 9-ны өдрийн 10 цагаас өмнө |
| 2. | 8-12-ны мэдээг | 13-ны өдрийн 10 цагаас өмнө |
| 3. | Эцсийн мэдээг | 15-ны өдрийн 9 цагаас өмнө |

**Сумын түр товчоод нь хөдөөгийн шалгагч нарын мэдээлсэн тооллогын явцын мэдээг сумын төв, бусад суурин газрын мэдээтэй нэгтгэж "А" хэсэгт заасан графикт хугацаанд (14 цагаас өмнө) аймгийн түр товчоонд мэдээлнэ.**

2.Тооллогын явцын мэдээг Маягт ХАОСТ-4-өөр гаргана. Тооллогын явцын мэдээ нь статистикийн шуурхай мэдээллийн зэрэгт хамаарч, мэдээг тасалсан, хожимдуулсан тухай бүр буруутай хүнд холбогдох хууль тогтоомжийн дагуу орон нутгийн статистикийн хэлтэс, тасаг, статистикийн улсын байцаагч нар хариуцлага хүлээлгэнэ.

3.ҮСГ тооллогын явцын мэдээг аймаг, нийслэлээр 1дүгээр сарын 6-ны өдрөөс эхлэн өдөр бүр 20 цагийн өмнө нэгтгэж дууссан байна.

### 6. Тооллогын явцын мэдээний Маягт ХАОСТ-4-г нөхөх заавар

Эдгээр маягтыг:

- тоологчид-өрхийн тэргүүлэгчийн нэрээр;
- шалгагчид-тоологчийн дугаараар;
- сум, баг, хороо-шалгагчийн дугаараар;
- аймаг-сумаар;
- дүүрэг-хороогоор;
- нийслэл-дүүргээр тус тус нэгтгэн гаргаж байна.

Улсын дүнг аймаг, нийслэлийн дүнгээр гаргаж тооллогын явцын тухай мэдээллийг нийтийн мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлэх арга хэмжээг ҮСГ-аас авч байна.

Маягт ХАОСТ-4-ийн 1-4-р баганад тооллогод зориулсан өрх, хүн амын бүртгэлээр тоологдох өрх, түүнчлэн өрх, нийтийн байр, бусад байранд тоологдох хүн амын тоо, бүх хүн амын тоог тус тусад нь нөхнө.

Маягт ХАОСТ-4-ийн 5-8-р баганад мэдээ гаргаж байгаа хугацаанд тоологдсон өрх, хүн амын тоог харгалзах баганад нь өсөн нэмэгдэх дүнгээр нөхнө.Нийтийн байрыг бүхэл байшингаар нь биш хүн сууж байгаа сууц (ажилчны нийтийн байр зэрэгт)-ны өрөө, тасалгааны тоогоор өрхийн тоо гэсэн баганад нөхнө.

Маягт ХАОСТ-4-ийн 9-12-р баганад тоологдсон, тоологдвол зохих өрх, хүн амын тоог харьцуулж хувийг нь тодорхойлно. Үүнд:

Багана 9 = багана 5 : багана 1 x 100
Багана 10 = багана 6 : багана 2 x 100
Багана 11 = багана 7 : багана 3 x 100
Багана 12 = багана 8 : багана 4 x 100

**в. Тооллогын материал, урьдчилсан дүнг хүлээж авах**

1. Тооллогын материалыг хүлээж авах бүх үе шатанд тооллогын хуудсанд нөхөгдсөн өрх, хүний тоог нэг бүрчлэн тоолж, урьдчилсан дүнтэй тулгаж авна. Хэрэв энэ хоёр үзүүлэлт тохирохгүй байвал тооллогын хуудсанд бичигдсэн өрх , хүний тоогоор урьдчилсан дүнгийн холбогдох үзүүлэлт нэг бүрийг засна.

2. Тооллогын материал хүлээн авах, урьдчилсан дүнг гаргах графикийн эхний 1,2,3-д заасан ажлыг энэ зааврын 5-ыг баримтлан хийнэ.

3. Тооллогод зориулсан өрх, хүн амын бүртгэлд байгаа өрх, хүн ам, орон сууцны тоо, тоологч нэг бүрийн тоолж, тооллогын хуудсанд нөхсөн өрх, хүн ам, орон сууцны тоо, урьдчилсан дүн эдгээр 3 үзүүлэлтийг тулган шалгаж хүлээн авна. Тооллогод зориулсан өрх, хүн амын бүртгэлд байгаа өрх, хүн амыг бүрэн тоолсон эсэхийг сайн шалгаж, илүү, дутуу тоолсон бол шалтгааныг тодруулна. Бүртгэлд бичигдсэн өрх, хүн амаас дутуу тоологдсон байвал тэдгээрийг тоолоогүй шалтгааныг тодруулж,

тооллогод хамрагдаагүй үлдсэн нь тогтоогдвол нөхөн тоолно. Хэрэв бүртгэлээс илүү хүн тоологдсон бол шалтгааныг тодруулж эдгээр хүмүүс өөр газар давхар тоологдсон эсэхийг холбогдох тооллогын комисстой холбоо барьж өөр газар давхар тоологдсон нь тогтоогдвол тооллогын аль комиссын харъяалах нутаг дэвсгэрийн дунд оруулахаа харилцан тохирох хэрэгтэй.

4. Тооллогын нөхөгдсөн хуудсыг Маягт ХАОСТ-5-аар хүлээж авна. Маягт ХАОСТ-5-ыг **сум, аймгийн төвийн баг, дүүргийн хорооны тооллогын түр товчоод тоологчоос тооллогын хуудсыг хүлээн авахдаа үйлдэнэ**.

5. Тооллогын хуудсыг хүлээж авах дараах зааврыг баримтлана. Үүнд:

•Тоологч бүрт Маягт ХАОСТ-5-ыг нээнэ. Нээсэн маягт бүрт тооллогын комисс, тооллогчийн дугаарыг бичнэ.

•Тухайн тоологчийн нөхсөн тооллогын хуудас (МаягтХАОСТ-1)-ны хамт Маягт ХАОСТ-5-ыг дагалдуулан хавтаслана.

•Тоологчийн нөхсөн тооллогын хуудасны эхний дугаараас эхлэн хуудас бүрт нөхөгдсөн хүн нэг бүрийг тоолж, тооллогын хуудасны нүүрэн талын тоологдсон хүний тоотой тохирч байгаа эсэхийг шалгахын хамт тооллогын хуудасны бөглөлтийн бүрэн, үнэн зөвийг шалгана.

•Тооллогын хуудасны нүүрэн талын сууц эзэмшлийн хэлбэр гэсэн асуултыг "Сууц эзэмшигч өрх-1", "Тухайн сууцанд хамт суудаг өрх-2" хоёрын аль нэгээр нөхсөн тохиолдолд өрх байна гэж үзэж Маягт ХАОСТ-5-ын " Өрх " гэсэн баганад "1" гэж бичнэ. Хэрэв нийтийн болон бусад байр гэж нөхсөн тохиолдолд хоосон орхино.

•Маягт ХАОСТ-5-ын "Тоологдсон хүний тоо" гэсэн баганад тооллогын хуудасны нүүрэн талын "Тоологдсон хүний тоо" гэсэн үзүүлэлтийг бичнэ . Тэгэхдээ энэ тооны үнэн зөв нь шалгагдсан байх ёстой.

•Тухайн тоологчийн тооллогын хуудсыг дугаарынх нь дагуу тоолж хүлээж авсны дараа хүснэгтийн доод талд өрхийн тоо, тоологдсон хүний тоог нэмж бичнэ.

•Маягт ХАОСТ-5-ын өрх, тоологдсон хүний тоо гэсэн үзүүлэлт, тухайн тоологчийн гаргасан урьдчилсан дүнтэй үзүүлэлт бүрээрээ тохирч байна.

Маягт ХАОСТ-5-ыг сум, аймгийн төвийн баг, хорооны түр товчоод анхлан үйлдэж дараагийн үе шатны түр товчоод тооллогын материалыг шалгаж хүлээж аваад тухайн үе шатны түр товчоодод харгалзах баганад зориулалтын тэмдэг "√" тавина.

Тооллогын хуудасны нөхөлтийг эдгээр үе шатанд тус бүр шат дараалан шалгаж, буруу нөхснийг засч, засагдсан үзүүлэлт нэг бүрээр урьдчилсан дүнг залруулна.

## Тооллогын материал, урьдчилсан дүнг хүлээн авах график

| Тооллогын материал, урьдчилсан дүнг хүлээлгэн өгөх үе шат | Хугацаа | |
|---|---|---|
| | Эхлэх | Дуусах |
| 1. Тоологчоос шалгагч хүлээн авах | 6/I | 15/I |
| 2.Шалгагч (тоологчийн хамт)-аас аймгийн төвийн сумын баг, дүүргийн хорооны түр товчоо хүлээн авах | 16/I | 20/I |
| 3. Шалгагч (тоологч)-аас хөдөөгийн сумын түр товчоо хүлээн авах | 16/I | 22/I |
| 4.Аймгийн төвийн сумын баг, дүүргийн хорооноос аймаг, УБ хотын дүүргийн түр товчоо хүлээн авах | 21/I | 27/I |
| 5. Бүх сумаас аймгийн түр товчоо хүлээн авах | 23/I | 1/II |
| 6. Дүүргээс Улаанбаатар хотын түр товчоо хүлээн авах | 28/I | 14/II |
| 7. Аймаг,нийслэлээс ҮСГ хүлээн авах | 11/II | 5/III |
| 8. Яамдын шугамаар байгуулагдсан тооллогын салбар түр товчоодоос яаманд хүлээн авах | Яамны комисс зохицуулна | 1/II |
| 9. Яамдын түр товчоодоос ҮСГ хүлээн авах | ҮСГ зохицуулна | 5/III |

6. Тооллогын материал, урьдчилсан дүнг хүлээн авах графикийн 4-7-р үе шатны ажлыг дараах зааврыг баримтлан хийнэ. Үүнд:

•Эдгээр түвшинд тоологдсон өрх, хүн амын тоог урьдчилсан дүнтэй тулган шалгаж, зөрүүтэй үзүүлэлтийг зөвхөн тооллогын хуудасныхаар засна.

•Тооллогын хуудасны нөхөлтийн үнэн зөвийг 4-6-р түвшинд 30-10 хувийг түүвэрлэн шалгасан байна.

•Маягт ХАОСТ-5-аар тооллогын дүн, материалыг хүлээж авсан хүн нэрээ бичиж, гарын үсгээ зурж баталгаажуулна.

7. Тооллогын газрын зургийг энэ зааврын IX бүлэгт заасны дагуу шат дараалан хүлээн авна.

**г. Хүн ам, орон сууцны тооллогын урьдчилсан дүнг гаргах**

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын урьдчилсан дүнгээр тоологдсон хүний тоог Маягт УД-1, Бэлэн хүн амын тоог МаягтУД-2, Суурин хүн амын тоог Маягт УД-3, Өрх, ам бүл, орон сууцны төрлийг Маягт УД-4-өөр, Хүн амын ажил эрхлэлтийг Маягт УД-5-аар гаргаж, графикийн дагуу тооллогын материал тушаахдаа шат дараалуулан хүлээлгэн өгнө.

Урьдчилсан дүнгийн маягт УД-1, 2, 3-ыг гаргахдаа тоологч өрхийн тэргүүлэгчээр, шалгагч тоологчийн дугаараар, сум, аймгийн төвийн сумын баг, хороо шалгагчийн дугаараар, аймаг сумаар, дүүрэг хороогоор, нийслэл дүүргээр тус тус гаргана.

**1. Тоологдсон хүн амын тоо, Маягт УД-1-ийг нөхөх тухай**

Энэ маягтаар тухайн орон нутагт хүн амын тооллогод хамрагдсан нийт хүний тоог, суурьшил, хүйсээр ангилан гаргана. Тооллогын хуудасны "**Суурьшил**" гэсэн 7-р асуултад байнга гэж хариулсан хүмүүсийн тоог хүйсээр нь ангилж 6,10-р баганад бичиж, 2-р баганад дүгнэнэ, түр суугаа гэж хариулсан хүнийг 7,11-р баганад хүйсээр ангилж, 2-р баганад дүгнэж бичнэ. Түр эзгүй гэж хариулсан хүнийг 8,12-р баганад бичиж, 4-р баганад дүгнэнэ. Эцэст нь 2,3,4, -р баганын нийлбэрээр тоологдсон бүх хүний тоог тодорхойлж, 1-р баганад бичнэ.

**2. Бэлэн хүн амын тоо, насны бүлгээр, хүйсээр, Маягт УД-2-ыг нөхөх тухай**

Энэ маягтаар тооллогын үед тухайн нутаг дэвсгэрт (аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо) оршин сууж байсан бэлэн хүн амын тоог гаргана. Бэлэн хүн амын тоог тодорхойлохдоо тоологдсон нийт хүн амаас түр эзгүй хүний тоог хасч тодорхойлно. Өөрөөр хэлбэл тоологдсон байнга, түр суугаа хүн амын тооны нийлбэр юм. Энэ маягтыг бөглөхдөө тооллогын хуудасны

7-р асуултад байнга, түр суугаа гэж хариулсан хүний тоог насны бүлэг, хүйсээр ялгаж гаргана. Хүснэгтийн баганын хоорондох уялдааг маягтад бичсэн тул тэдгээрийг сайтар анзаарч тоог ягштал дөрвөлжлөн баланслуулах хэрэгтэй.

Тухайн нутаг дэвсгэрийн УД-2 маягт, УД-1 маягтын үзүүлэлтийн хоорондын уялдаа:

| | Маягт УД-2 | | Маягт УД-1 |
|---|---|---|---|
| Багана | 1 | = | 2+3 |
| Багана | 6 | = | 6+7 |
| Багана | 11 | = | 10+11 |

**3. Суурин хүн амын тоо, насны бүлгээр, хүйсээр, Маягт УД-3-ыг нөхөх тухай**

Энэ маягтаар тооллогын үед тухайн нутаг дэвсгэрт (аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо) оршин сууж байгаа суурин хүн амын тоог харуулах юм. Суурин хүн амын тоог тодорхойлохдоо тоологдсон нийт хүн амаас түр суугаа хүний тоог хасч тодорхойлно. Өөрөөр хэлбэл тоологдсон байнга, түр эзгүй хүн амын тооны нийлбэр юм. Энэ маягтыг бөглөхдөө тооллогын хуудасны 7-р асуултад байнга, түр эзгүй гэж хариулсан хүний тоог насны бүлэг, хүйсээр ялгаж гаргана. Хүснэгтийн баганын хоорондох уялдааг маягтад бичсэн тул тэдгээрийг сайтар анзаарч тоог ягштал дөрвөлжлөн баланслуулах хэрэгтэй.

Тухайн нутаг дэвсгэрийн УД-3 маягт, УД-1 маягтын үзүүлэлтийн хоорондын уялдаа:

| | Маягт УД-3 | | Маягт УД-1 |
|---|---|---|---|
| Багана | 1 | = | 2+4 |
| Багана | 6 | = | 6+8 |
| Багана | 11 | = | 10+12 |

## 4. Өрх, сууцны төрөл, Маягт УД-4-ийг нөхөх тухай

Урьдчилсан дүнгийн энэ маягтаар өрхийн тоог, өрхөд тоологдсон хүний тоогоор болон сууцны төрлөөр гаргана.

Урьдчилсан дүнгийн энэ маягтын "Бүгд" гэсэн 1-р баганад тооллогын хуудасны нүүрэн талын "Сууц эзэмшигч өрх-1", "Тухайн сууцанд хамтран суудаг өрх –2" гэж тоологдсон өрхүүдийн тоог, мөн тооллогын хуудасны нүүрэн талын тоологдсон хүний тоогоор ангилж гаргана.

Бүх өрхийг хот, хөдөөгөөр ангилж, хөдөөгийн өрхөөс сумын төвийн өрхийн тоог сугалж гаргана. Хотын өрхөд аймгийн төв, нийслэл, тосгонд оршин суудаг өрхийг хамруулна. Хөдөөгийн өрхөд сумын төв, хөдөөгийн өрхийг хамруулна.

## 5. Хүн амын ажил эрхлэлт, Маягт-УД-5-ыг нөхөх тухай

Энэ маягтаар хүн амын ажил эрхлэлтийн байдлыг гаргана.

Хүн амын ажил эрхлэлтийн байдлыг суурин хүн амаар гаргана. Суурин хүн амын тоо –бүгд гэсэн 1-р баганад урьдчилсан дүнгийн маягт УД-3-ын 1-р баганын, эрэгтэй гэсэн 2-р баганад 6-р баганын, эмэгтэй гэсэн 3-р баганад 11-р баганын тоонуудыг шууд хуулж бичнэ. Харин 15-59 насны (хөдөлмөрийн насны) гэсэн 2-р мөрний 1-р баганад урьдчилсан дүнгийн маягт УД-3-ын 3,4-р баганын нийлбэр, эрэгтэй гэсэн 2-р баганад маягт УД-3-ын 8,9 –р баганын нийлбэр, эмэгтэй гэсэн 3-р баганад, маягт УД-3-ын 13,14-р баганын нийлбэрийг бичнэ.

Маягтын 3-р мөрөнд тооллогын хуудасны 14-р асуултад ажил эрхэлдэг "Тийм-1" гэж хариулсан хүний тоог эрэгтэй, эмэгтэйгээр ангилж гаргана. Харин 4-р мөрөнд 14-р асуултад "Үгүй-2" гэж хариулсан хүний тоог эрэгтэй, эмэгтэйгээр нь ангилж гаргана. Маягтын 5-11-р мөрөнд тооллогын хуудасны 19-р асуултын холбогдох хариултад хариулсан хүний тоог эрэгтэй, эмэгтэйгээр бичнэ.

Маягтын 3,4-р мөрөнд бичигдсэн тооны нийлбэр нь 2-р мөрийн 15-59 насны хүн амын тоотой багана тус бүрээрээ тохирч байх ёстой.

## 6. Тооллогын материалыг эмхлэн хүлээлгэн өгөхөд бэлтгэх

Нэг багцанд 125-аас доошгүй өрхийн тооллогын хуудас байхаар бодож материалыг эмхлэн цэгцэлнэ. Тэгэхдээ:

а. Хавтасны гадна талд цагаан цаасан дээр дараах хаягийг бичиж наана.

Код

Аймаг, нийслэлийн нэр -------------------------- ☐☐

Сум, дүүргийн нэр --------------------------------- ☐☐

Баг, хорооны нэр------------------------------------

Тооллогын комиссын дугаар --------------------☐☐☐

Тоологчийн дугаарууд ☐☐ ☐☐ ☐☐

Өрхийн тоо-------------------, Хүн амын тоо-------------

Хавтасны гадна талд дээрхээс өөр зүйл бичихийг хатуу хориглоно.

б. Хавтасны нуруун талд: Сум, дүүргийн нэр, хавтасны дугаарыг жижиг цаасан дээр гараар бичиж наана.

в. Нэг хавтасны дотор талд:

1. Тоологч нэг бүрээр гаргасан урьдчилсан дүн, тооллогын хуудсыг дугаараар нь дараалуулан байрлуулсан байна

2. Нэг хавтсанд хоёр өөр сум, хорооны тооллогын хуудсыг хольж хийж болохгүй.

